

Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсгийн Орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн суурь судалгааны тайлан



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	2
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ТАЛАРХАЛ.....	5
ХУРААНГУЙ	6
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	7
Судалгааны зорилго	7
Судалгааны арга зүй.....	7
Газарзүйн хамрах хүрээ ба судалгааны түүвэр.....	9
ХОЁР. ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН “А” ХЭСГИЙН ОРЧНЫ БҮСИЙН МАЛЧДЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	10
Судалгаанд оролцогчдын мэдээлэл.....	10
Өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндийн байдал, эмзэг бүлгийн мэдээлэл	13
Өрхийн амьдралын нөхцөл	15
Өрхийн аж ахуй болон эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт	21
Олон хэмжээст ядуурлын индекс	30
ГУРАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ БОЛОН ОРЧНЫ БҮСИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ МАЛЧДЫН ХАНДЛАГА, ОЙЛГОЛТ	32
4.1. Зорилт 1. ГИДЦГ-ын орчны бүсийн судалгаа, камерын хяналт, эргүүл хамгааллын тогтолцоог бэхжүүлэх.....	32
4.2. Зорилт 2. ГИДЦГ-ын есосистемийг нөхөн сэргээх уст цэг ба амьдрах орчны менежментийн загвар гаргах	34
4.3. Зорилт 3. ГИДЦГ-ын орчны бүсийн менежментийг хэрэгжүүлэх хамтарсан засаглалын институцийг дэмжих.....	37
4.4. Зорилт 4. Иргэдийн дунд бэлчээрийн болон сүргийн менежментээ сайжруулах, байгаль орчноо хамгаалах мэдлэг хандлагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааг нөхөрлөл болон эко-клубаар дамжуулан хийх.....	40
4.5. Зорилт 5. Малчдын байгалийн нөөцийг тогтвортой ашиглалт, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих	42
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	45
Дүгнэлт	45
Санал зөвлөмж	47

ТОВЧИЛСОН ҮГС

БНХМ
БЖИ
ГИДЦГ
ЛАСН
IRIM

Байгалийн нөөцийн хамтын менежмент
Биеийн жингийн индекс
Говийн Их Дархан Цаазат Газар
Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг
Хараат бус судалгааны хүрээлэн

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ, зорилтот байршлаар	9
Хүснэгт 2. Өрхийн гишүүдийн үндэс, угсаа тоогоор, %, N=309	12
Хүснэгт 3. Нийт гишүүдийн тоонд эмзэг бүлэгт хамаарах гишүүдийн тооны эзлэх хувь	13
Хүснэгт 4. Өрхийн эрхэлдэг аж ахуйн төрөл/давхардсан тоогоор, зорилтот багаар/, %	22
Хүснэгт 5. Орлого олдог гишүүдийн тоо /байршлаар/, %	23
Хүснэгт 6. Орлогын эх сурвалж ба хөдөлмөр эрхлэлтийн байдал	23
Хүснэгт 7. Эмзэг болон ядуу өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр	23
Хүснэгт 8. Өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр, /оноор/	24
Хүснэгт 9. Өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр, /зорилтот багаар/	25
Хүснэгт 10. Өрхийн орлогын бүлэг /зорилтот багаар, %/	25
Хүснэгт 11. Өрхийн жилийн дундаж зардал, мөнгөн дүнгээр, /оноор/	26
Хүснэгт 12. Өрхийн жилийн зарлага, %, /зорилтот сумаар/	27
Хүснэгт 13. Өрхийн хадгаламж, %, /зорилтот багаар/	28
Хүснэгт 14. Өрхийн зээл, %, /зорилтот бүлгээр/	29
Хүснэгт 15. Өрхийн эдийн засгийн идэвхжилтийн байдал, %, /зорилтот багаар/	29
Хүснэгт 16. Олон хэмжээст ядуурлын үзүүлэлтүүд	30
Хүснэгт 17. Эдийн засгийн сайн сайхан байдлын боломжит хэмжүүрүүд	31
Хүснэгт 18. Байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон байдал, %, N=69	32
Хүснэгт 19. Бэлчээрийн нөхцөл байдалд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69	32
Хүснэгт 20. Бэлчээрийг нөхөн сэргээх хамгаалах ажлын хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69	33
Хүснэгт 21. Заган ойн нөхцөл байдал сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69	34
Хүснэгт 22. Зэрлэг амьтны тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69	34
Хүснэгт 23. Зэрлэг амьтад харсан байршил,	0
Хүснэгт 24. Сүүлийн 2 жилийн хугацаанд байгаль орчны зөрчилд гарсан өөрчлөлт, %, N=69	35
Хүснэгт 25. Байгаль орчны зөрчил голлон гарч буй сарууд, %,	35
Хүснэгт 26. Байгаль орчны зөрчил гарч буй газрууд, байршлаар	36
Хүснэгт 27. Орон нутгийн байгаль орчинд тулгарч байгаа хамгийн хүндрэлтэй асуудлууд, байршлаар, %,	40
Хүснэгт 28. Бодомж ач холбогдолын түвшингээр, %, N=69	42
Хүснэгт 29. Байгал хамгалал, бэлчээр ашиглалтын мэдлэг, хандлагын индекс оноо	42
Хүснэгт 30. Дараах бодомжуудад санал нийлэх эсэх, %, N=69	43
Зураг 1. Судалгааны арга зүйн хүрээ	7
Зураг 2. Судалгааны загвар	8
Зураг 3. Газарзүйн хамрах хүрээ	9
Зураг 4. Судалгаанд оролцогчдын тоо, Насны ангиллаар, %, N=69	10
Зураг 5. Гэрлэлтийн байдал, хүйсээр, %, N=69	10
Зураг 6. Боловсролын түвшнээр, %, N=69	12
Зураг 7. Боловсролын түвшин, хүйсээр, %, N=69	12
Зураг 8. Боловсролын түвшнээр хистограмм, насанд хүрсэн нийт өрхийн гишүүдээр, N=219	13
Зураг 9. Өрхийн гишүүдийн боловсрол, байршлаар, N=219	14
Зураг 10. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, N=69	14

Зураг 11. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, төслийн зорилтот байршлаар, N=69	15
Зураг 12. Өрх тус бүрийн гишүүдийн БЖИ, N=181	15
Зураг 13. Өрхийн амьдарч буй сууцны төрөл, зорилтот байршлаар, N=69	16
Зураг 14. Өрхийн сууцны шалны үндсэн материал, байршлаар, %, N=69	16
Зураг 15. Өрхийн амьдарч буй сууцны нөхцөл, зорилтот байршлаар, %, N=69	17
Зураг 16. Өрхийн цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=69	17
Зураг 17. Өрхийн ундны усны гол эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=69	18
Зураг 18. Ундны цэвэр усны үүсвэрт хүрэх хугацаа, %, N=69	18
Зураг 19. Өрхийн бие засах газрын төрөл, зорилтот байршлаар, %,	19
Зураг 20. Дулаан хангамжийн эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=69	19
Зураг 21. Ахуйн өргөн хэрэглээний эд зүйлстэй өрх, N=69	20
Зураг 22. Тээврийн хэрэгсэлтэй өрх, %, N=69	20
Зураг 23. Өрхийн нийгмийн аж байдлын түвшин, %, /өөрийн субъектив үнэлгээгээр/	21
Зураг 24. Өрхийн амьдралын түвшний өөрчлөлт/төслийн зорилтот багаар/	22
Зураг 25. Орлого олдог гишүүдийн тоо, %,	24
Зураг 26. Өрхийн жилийн орлогын бүлэг/нийт өрхөд эзлэх, %/	25
Зураг 27. Өрхийн жилийн нийт зарлага, %, /оноор/	27
Зураг 28. Өрхийн орлогын хүрэлцээ, %, /зорилтот багаар/	28
Зураг 29. Амьдралын сэтгэл ханамж, %, /зорилтот багаар/	30
Зураг 30. Бэлчээр хамгаалах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төрөл, %, N=69	33
Зураг 31. Бэлчээрийг сэргээж хамгаалахад шаардлагатай үйл ажиллагааны чиглэл, %, N=69	33
Зураг 32. Хар сүүлт харсан давтамж, %, N=57	34
Зураг 33. Хар сүүлт харсан байдал, %, N=69	34
Зураг 34. Хавтгай тэмээний харсан байдал, %, N=67	1
Зураг 35. Хавтгай тэмээ харсан давтамж, %, N=24	1
Зураг 36. Хулангийн харсан байдал, %, N=68	1
Зураг 37. Хулан харсан давтамж, %, N=20	1
Зураг 38. Ирвэсийн харсан байдал, %, N=68	1
Зураг 39. Ирвэс харсан давтамж, %, N=12	1
Зураг 40. Чоно харсан байдал, %, N=67	0
Зураг 41. Чоно харсан давтамж, %, N=49	0
Зураг 42. Байгаль орчны зөрчлийг хэн үйлдэж байна, %,	36
Зураг 43. ГИДЦГ-ын Орчны бүсийн менежментийн талаар сонссон эсэх, %, N=69	37
Зураг 44. Орчны бүсэд хэрэгжиж буй үйл ажиллагаа аль хэр явагдаж байгаа эсэх, %, N=52	37
Зураг 45. Нутгийнхаа амьтан, ургамлын талаар мэдэх эсэх, %, N=69	37
Зураг 46. БНХМ нөхөрлөлд гишүүнчлэлтэй эсэх, %, N=69	40
Зураг 47. Байгаль орчин, цаг агаарын мэдээлэл авч буй мэдээллийн суваг, %, N=69	41

ТАЛАРХАЛ

Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн 2021-2024 оны хооронд хэрэгжүүлж байгаа “Их говийн нүүдэлч малчдыг дэмжин хавтгай тэмээг хамгаалах” төслийн хүрээнд Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) ТББ нь “Говийн Их Дархан Цаазат Газрын (ГИДЦГ) “А” хэсгийн Орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн суурь судалгааны тайлан”-г 2022 оны 02-р сарын 15-аас 03-р сарын 15-ны хооронд боловсруулав.

Судалгааны ажлын зорилго нь ГИДЦГ “А” хэсгийн орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцох замаар тодорхойлох болон орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгааллын асуудал, оршин суугаа нутгийнхаа байгаль, зэрлэг амьтдад хандах малчдын мэдлэг, хандлагыг тодорхойлоход чиглэсэн.

Судалгааны ажлыг гүйцэтгэхэд ЛАСН-ийн хамт олны туслалцаа маш их байсан бөгөөд тэр дундаа судалгааны ажлын явцад үнэтэй зөвлөгөө, удирдамж, мэдээллээр хангасан ЛАСН-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын захирал У. Тунгалаг, төслийн мэргэжилтэн Р. Болор, Ш. Мягмарсүрэн болон судалгаанд идэвхтэй оролцсон орон нутгийн удирдлага, албан хаагч болон нөхөрлөлийн ахлагч, гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагч та бүхэнд талархал илэрхийлье.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажил нь ГИДЦГ “А” хэсгийн орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцох замаар тодорхойлох, орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгаалал, зэрлэг амьтдад хандах хандлага, мэдлэгийг тодорхойлоход чиглэсэн.

Судалгаанд ГИДЦГ “А” хэсгийн орчны бүсийн 5 багийн 69 өрхөөс асуумж судалгааг нүүр тулсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Судалгааны тайлан нь (i) Судалгааны аргазүй, аргачлал (ii) Орчны бүсийн малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, (iii) Орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгаалал (iv) Дүгнэлт, Санал зөвлөмж гэсэн дөрвөн үндсэн бүлгээс бүрдсэн.

Зорилтот багуудын амьжиргааны түвшинг илтгэх олон хэмжээст ядуурлын индекс 0.114 гарсан. Нийт өрхөд эзлэх ядуу өрх 28.2% ба эдгээр ядуу өрхийн 11.4% нь бүх индикатор үзүүлэлтийн хувьд гачигдалтай байна. Өрхүүдийн хөрөнгө эзэмшил болон нялхсын эндэгдлийн үзүүлэлтүүд боломжийн түвшинд байсан боловч амьжиргааны түвшний бусад үзүүлэлт нь маш хангалтгүй хэмжээнд байна. Тухайлбал өрхүүдийн ядуурлын түвшин өндөр гарахад ундны усны найдвартай эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдал, гэр, байр, орон сууцны шалны материал, хангамж, хоол унд хийх түлшний хэрэглээ зэрэг нь хамгийн өндөр нөлөө үзүүлсэн. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн дундаж орлого 2021 онд өмнөх оноос 8.6 хувиар өссөн боловч түүнийг дагаад зарлагын хэмжээ 7.7 хувиар өссөн байна. Орчны бүсийн малчдын амьжиргааны гол эх үүсвэр нь сүү, сүүн бүтээгдэхүүн болон ноос, ноолуур, махны борлуулалт байна. Өрхийн ноос, ноолуурын орлого 2020 онтой харьцуулахад 2021 онд нэмэгдсэн бол мал зарах, малын махнаас олох орлогын хэмжээ буурсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 31.9 хувь хадгаламжтай байна. Зээлтэй өрхийн тоо 2021 онд өмнөх оноос 8.7 хувиар нэмэгдсэн ба зээлтэй өрхийн тоо зорилтот бүх багт нэмэгдсэн байдалтай байна. Нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагдсан байдал нь тун хангалтгүй, нийт өрхийн ердөө 2.9% нь хуримтлалын санд хамрагдсан.

Нутгийн иргэдийн санаа хамгийн ихээр зовж буй асуудал нь усны хомсдол байна. Үүнтэй холбоотойгоор уст цэгийн тоог нэмэгдүүлэх, худаг гаргах шаардлагатай байгааг малчид тэмдэглэжээ. Усны хүрэлцээ, хангамж муу байгаагаас бэлчээрийн нөхцөл байдал муудсан буюу доройтсон гэж нутгийн иргэдийн дийлэнх буюу 64.7% нь үзэж байна. Бэлчээрийг сэргээж хамгаалах чиглэлд иргэдийн зүгээс уст цэгийн тоог нэмэгдүүлэх, худаг гаргах, малын тоог бууруулах, чанаржуулах, бэлчээрийг хашаалах, өнжөөх, сэлгэн нүүдэллэх, үүлэнд нөлөөлж бороо оруулах гэсэн саналуудыг гаргажээ. Мөн төслөөс заган ойг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд тусгайлан ач холбогдол өгөх шаардлагатай байна. Учир нь нутгийн иргэдийн 55.1% нь сүүлийн 3 жилийн хугацаанд заган ойн нөхцөл байдал муудсан буюу доройтсон хэмээн үзэж байна.

Сүүлийн 2 жилийн хугацаанд хулгайн ан хийх, заг бэлтгэх, эмийн ургамал түүх, бичил уул уурхай эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад иргэдийн дийлэнх буюу 75% орчим нь мэдэхгүй хэмээн хариулсан. Зэрлэг амьтдын болон хулгайн ангийн байршил давхцаж байна. Мөн хулгайн ан хийж байгаа иргэдийн дийлэнх нь нутгийн иргэд, сум болон аймгийн төвийн иргэд байж болзошгүй юм.

Нутгийн иргэдийн дунд ГИДЦГ-ын орчны бүсийн менежмент болон тэдний үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл бүхий иргэд цөөн байна. Мөн нутгийн иргэдийн 43.5% өөрсдийнхөө нутгийн амьтан, ургамлын талаар дунд зэрэг мэдлэгтэй болон огт мэдэхгүй гэсэн хариултыг өгч байна. Нутгийн иргэдийн 24.6% нь БНХМ нөхөрлөлд гишүүнчлэлтэй байна. Нутгийн иргэдийн 91.6% нь байгаль орчин, цаг уурын талаарх мэдээллийг зөвхөн телевизээс авч байна.

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго

Судалгааны ажлын зорилго нь ГИДЦГ “А” хэсгийн орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцох замаар тодорхойлох болон орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгааллын асуудал, оршин суугаа нутгийнхаа байгаль, зэрлэг амьтдад хандах иргэдийн мэдлэг, хандлагыг тодорхойлоход чиглэсэн болно.

Судалгааны арга зүй

Судалгааны арга зүйн ерөнхий хүрээг доорх зурагт үзүүлэв. Судалгааны баг зорилгодоо хүрэхийн тулд үндсэн хоёр зорилтыг дэвшүүлсэн.

Зураг 1. Судалгааны арга зүйн хүрээ



Зорилт 1. Аргачлал: Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсгийн Орчны бүсийн малчдын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ) тооцохдоо дараах хоёр төрлийн ядуурлын гүнзгийрлийг хэмжинэ. Үүнд:

1. Ядууралд хамрагдах тохиолдол буюу (өгөгдсөн хүн амын) олон хэмжээст ядууралд өртсөн хүн амын харьцаа
2. Ядууралд хамрагдах тохиолдол буюу (өгөгдсөн хүн амын) гачигдал хомсдолын эрчимжилт буюу гачигдал хомсдолын жинлэгдсэн дундаж харьцаа

ОХЯ-ийн индексийг тооцох аргачлалыг уг тайлангийн “Өрхийн аж ахуй болон эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт” хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн.

Зорилт 2. Аргачлал: Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсгийн Орчны бүсийн байгалийн нөөц, түүний доройтол, хамгаалалын асуудалд төслийн зорилтот бүс нутгийн иргэдийн мэдлэг ойлголт, хандах хандлагыг тодорхойлсон. Тус зорилгод хүрэхийн тулд судалгааны баг нийт 69 өрхөөс авсан тоон өгөгдлийг ашиглан энгийн статистик шинжилгээ, судалгааны түлхүүр үзүүлэлт болон хүн, ам зүйн мэдээлэлтэй харьцуулсан шинжилгээ хийсэн.

Судалгааны загвар: Энэхүү судалгааг хийхдээ өмнө ба дараа судалгааны загварыг ашигласан. Загварын дэлгэрэнгүйг доорх зурагт үзүүлэв.

Зураг 2. Судалгааны загвар



A_1 нь зорилтот бүлгийн суурь судалгааны үр дүн, A_2 нь зорилтот бүлгийн эцсийн шатны үнэлгээний үр дүн. X нь энэхүү төслийн гол үр дүн. Төслийн эцсийн үр дүнгийн интервенц нь X -ээр хэмжигдэнэ. Энэхүү судалгааны загвар нь суурь судалгааг хэмжигдэхүйц, харьцуулагдахуйц, давтагдах боломжтой болгож өгнө.

Хяналт, үнэлгээ: “Их говийн нүүдэлч малчдыг дэмжин хавтгай тэмээг хамгаалах” төслийн нийгэм-эдийн засгийн суурь судалгаа нь цаашид төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргаар харьцуулах боломжтой байх ёстой. Иймд суурь судалгааны үр дүнг гаргахдаа дунд болон эцсийн шатны үнэлгээтэй харьцуулах боломжтой аргыг ашиглана.


Байршил: Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэгт хамаарах Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн баг, Шинэжинст сумын Уртын гол баг, Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт баг, Цогт сумын Баянтоорой тосгон болон Эрдэнэ сумын Өлзийт багийг хамруулсан.

Цаг хугацаа: Суурь судалгааг 2021 оны 07-р сарын 01-ээс 2022 оны 04-р сарын 25 хүртэлх хугацаанд хийсэн. Эцсийн шатны судалгааг 2024 онд хийхээр төлөвлөж байна.

Газарзүйн хамрах хүрээ ба судалгааны түүвэр

Судалгааны тоон мэдээллийг төслийн зорилтот Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэгт хамаарах Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн баг, Шинэжинст сумын Уртын гол баг, Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт баг, Цогт сумын Баянтоорой тосгон болон Эрдэнэ сумын Өлзийт багийг хамруулан 2022 оны 1-р сард зохион байгуулан, цуглуулсан. Судалгааны мэдээллийг цуглуулсан байршлыг доорх зурагт харуулав.

Зураг 3. Газарзүйн хамрах хүрээ



Суурь судалгааны анхдагч мэдээллийг дээрх талбаруудаас тухайн орон нутгийн өрхүүдийн төлөөллийг оролцуулан цуглуулсан. Судалгаанд оролцогчдын түүврийн дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1-д харууллаа.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ, зорилтот байршлаар

#	Зорилтот байршил	Түүврийн хэмжээ, төөн-утгаар сонгогдсон өрхийн тоо	Түүвэрт эзлэх хувь
1	Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	14	20.3%
2	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	14	20.3%
3	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	10	14.5%
4	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	16	23.2%
5	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг	15	21.7%
Нийт		69	100%

ХОЁР. ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН “А” ХЭСГИЙН ОРЧНЫ БҮСИЙН МАЛЧДЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Тайлангийн энэ хэсэгт Говь-Алтай аймгийн Алтай, Эрдэнэ, Цогт, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст гэсэн 5 сумын 5 багийн орчны бүсийн 69 өрхийн мэдээллийг авч үзсэн.


Судалгаанд нийт 69 өрхийг хамруулж, өрх тус бүрээс насанд хүрсэн, шийдвэр гаргах түвшний нэг гишүүнийг оролцуулав. Эдгээр судалгаанд оролцсон гишүүдийн 52 нь өрхийн тэргүүлэгч, 14 нь эхнэр эсвэл нөхөр, 3 нь хүү эсвэл охин байв. Судалгаанд оролцогчдын 75.4% буюу 52 нь эрэгтэй, үлдсэн 24.6% буюу 17 нь эмэгтэйчүүд байна. Асуулгаар тухайн 69 өрхийн 309 гишүүний мэдээллийг цуглуулсан болно.

Насны бүтцийн хувьд хамгийн багадаа 20 настай, хамгийн ихдээ 79 настай, дунджаар 41 насны оролцогчид судалгаанд хамрагджээ. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны ашигладаг насны ангиллаар судалгаанд оролцогчдын насыг ангилсан ба Зураг 4-д үзүүлэв. Нийт судалгаанд оролцогчдын 39.1% буюу гурван оролцогч тутмын хоёр нь 30-49 насныхан, 20-29 насны оролцогчдын хувьд харьцангуй цөөн буюу 14.5%-ыг бүрдүүлсэн байна. Ахмад буюу 50-аас дээш насны оролцогчид 18.8%-ыг бүрдүүлжээ.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэрлэлтийн байдалд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор гэрлэлтийн байдлыг Зураг 5-д хүйсээр ялган зураглалаа. Судалгаанд огт гэрлээгүй, батлуулаагүй эмэгтэй болон гэрлэлтээ цуцалсан эрэгтэй хүн оролцоогүй байна. Харин судалгаанд хамрагдсан 52 эрэгтэйчүүдийн 13.5% нь гэрлээгүй байна.

Иймд эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн гэрлэлтээ батлуулсан байдал нь ялгаагүй өндөр байна. Гэвч огт гэрлээгүй болон батлуулаагүй эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийн хувиас өндөр байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын тоо, Насны ангиллаар, %, N=69




Зураг 5. Гэрлэлтийн байдал, хүйсээр, %, N=69



Судалгаанд хамрагдсан оролцогчдын боловсролын түвшин харьцангуй доогуур байв. Зураг 6-аас харахад бакалавр болон түүнээс дээш боловсролтой оролцогч нийт түүврийн 5.8%-ийг л бүрдүүлж, үлдсэн 94.2% нь бүрэн дунд болон түүнээс доош түвшний боловсролтой оролцогчид байна. Тухайлбал,

нийт 69 иргэний 27 иргэн буюу 39.1% бүрэн дунд, 29 иргэн буюу 42% суурь, 7 иргэн буюу 10.1% бага боловсролтой, 2 иргэн буюу 2.9% нь боловсролгүй байна.

Зураг 6. Боловсролын түвшнээр, %, N=69



Эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн боловсролын түвшинд ялгаа байгаа эсэхийг тодруулах зорилгоор Зураг 7-нд боловсролын түвшинг хүйсээр ялган зураглалаа. Боловсролын түвшний хувьд нийт иргэдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байгаагийн дотор эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд боловсролгүй, эсвэл бага, дунд боловсролтой байх нь нийтлэг байна. Эсрэгээрээ, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн суурь болон бүрэн дунд боловсрол арай илүү байгаа хэдий ч бакалавр болон түүнээс дээш зэргийн боловсрол бага байгаа нь түүврийн хувьд эмэгтэйчүүд цөөн оролцсонтой холбоотой байж болох юм.

Зураг 7. Боловсролын түвшин, хүйсээр, %, N=69



Ам бүлийн хувьд ганцаараа амьдардаг гурван өрх байсан бол хамгийн ихдээ 9 ам бүлтэй өрх байв. Судалгаанд оролцогч өрхүүд дунджаар 4-5 ам бүлтэй, 4-5 хүүхэдтэй, өрхийн тэргүүлэгч эсвэл гол орлого ологч энэ нутагтаа 38 жил амьдарч байгаа өрхүүд судалгаанд хамрагджээ.

Хүснэгт 2. Өрхийн гишүүдийн үндэс, угсаа тоогоор, %, N=309

№	Эмзэг бүлэг	Суурь үнэлгээ, n=309	
		Тухайн бүлэгт хамрагдах иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Халх	309	100.0%
2	Буриад	0	0%
3	Казак	0	0%

4	Өөлд	0	0%
5	Дөрвөд	0	0%
6	Бусад	0	0%
Нийт		309	100.0%

Судалгаанд хамрагдсан 69 өрхийн гишүүд нь халх ястан байна. Дөрвөд, казак, өөлд, хотон, дархад, буриад үндэс, угсаатан судалгаанд хамрагдаагүй..

Өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндийн байдал, эмзэг бүлгийн мэдээлэл

Тайлангийн энэхүү хэсэгт өрхийн гишүүдийн боловсрол болон эрүүл мэндийн байдал, эмзэг байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг авч үзлээ.


Эмзэг бүлэг: Суурь судалгаанд хамрагдсан 69 өрхийн 309 гишүүдийн нэг өнчин хүүхэд, хоёр бэлэвсэрсэн, есөн хөгжлийн бэрхшээлтэй оролцогч байна. Харин таваас доош насны хүүхдийн эндэгдэл, болон өвчтэй байгаа оролцогч байхгүй байлаа. Нийт дүнгээр харахад, эдгээр эмзэг бүлэгт хамрагдах тоо суурь судалгаанд 12 буюу нийт гишүүдийн 3.9% эзэлж байна. Төслийн суурь судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн дотор эмзэг бүлэгт хамрагдах гишүүдийн тоо, эзлэх хувийг Хүснэгт 3. Нийт гишүүдийн тоонд эмзэг бүлэгт хамаарах гишүүдийн тооны эзлэх хувь-д харуулав

Хүснэгт 3. Нийт гишүүдийн тоонд эмзэг бүлэгт хамаарах гишүүдийн тооны эзлэх хувь

№	Эмзэг бүлэг	Суурь судалгаа, N=309	
		Тухайн бүлэгт хамрагдах иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Өнчин хүүхэд	1	0.32%
2	Бэлэвсэрсэн	2	0.65%
3	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүн	9	2.91%
Нийт		12	3.9%

Боловсролын байдал: Судалгаанд хамрагдсан өрхийн нийт насанд хүрсэн гишүүдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байв. Зураг 8-нд үзүүлсэн хистограммаас харахад нийт өрхийн гишүүдийн 18.7% бакалавр болон түүнээс дээш зэргийн боловсролтой, үлдсэн 81.3% нь бакалаврын бус зэргийн, техник, мэргэжлийн боловсрол болон түүнээс доош түвшний боловсролтой байна. Тухайлбал, нийт өрхийн 219 насанд хүрсэн гишүүнээс 76 гишүүн буюу 34.7% бүрэн дунд, 71 гишүүн буюу 32.4% суурь, 25 гишүүн буюу 11.4% бага, 6 гишүүн буюу 2.7% нь боловсролгүй байна.


Зураг 8. Боловсролын түвшнээр хистограмм, насанд хүрсэн нийт өрхийн гишүүдээр, %, N=219



Төслийн зорилтот байршлаар гишүүдийн боловсролын түвшинд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 9-нд боловсролын түвшинг байршлаар ялган харууллаа. Судалгаанд оролцогч өрхийн насанд хүрсэн гишүүдийн боловсролын түвшинг байршлаар нь харьцуулахад Говь-Алтай аймгийн Алтай

сумын Урт баг (22.9%) болон Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны (24.6%) өрхийн гишүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөр буюу бакалавр болон түүнээс дээш зэргийн боловсролтой байв. Харин Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн багийн (7.9%) хувьд бусад байршлаас боловсролгүй гишүүд хувь харьцангуй өндөр нь байна.


Зураг 9. Өрхийн гишүүдийн боловсрол, байршлаар, %, N=219



Суурь судалгааны хувьд өрхийн насанд хүрсэн гишүүдийн дотор бага болон түүнээс доош (тав болон түүнээс доош анги) боловсрол эзэмшсэн гишүүнтэй 24 өрх байв. Энэ нь нийт судалгаанд хамрагдсан өрхийн 34.8% байгаа нь өрхийн насанд хүрсэн гишүүдийн боловсрол харьцангуй доогуур байгааг илтгэж байна. Харин сургууль завсардсан сургуулийн насны (6-14 нас) хүүхэдтэй хоёр өрх суурь судалгаанд хамрагджээ.

Эрүүл мэндийн байдал: Суурь судалгаанд хамрагдсан 69 өрхийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гишүүдийн тоогоор авч үзэхэд 94.2% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол үлдсэн 5.8% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байна. Тухайлбал, 1-3 гишүүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал-24.6%, 4-6 гишүүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал-63.8%, 7 ба түүнээс дээш гишүүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал-5.8% байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадаагүй шалтгааныг тодруулахад эрүүл мэндийн даатгалын шаардлага гардаггүй гэсэн хариултыг өгчээ. Эндээс үзвэл нийт өрхийн 5.8% нь эрүүл мэндийн даатгалын хөнгөлттэй үйлчилгээг авдаггүй байна. Төслийн суурь судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг гишүүдийн тооны интервал болон нийт өрхөд эзлэх хувиар Зураг 10-нд харуулав.


Зураг 10. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, %



Төслийн зорилтот байршлаар эрүүл мэндийн даатгалд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 11-т эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдлыг байршлаар ялган харууллаа. Зорилтот 5 байршлаас


Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн баг, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол баг болон Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт баг 100%-тай байгаа бол Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт баг 90%, Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгон 81.3%-тай хамрагдсан байна.

Зураг 11. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, төслийн зорилтот байршлаар, %, N=69



Өрхийн гишүүдийн биеийн өндөр болон жингийн мэдээллийг өрх тус бүрээс судалгаа авахдаа цуглуулж, биеийн жингийн индекс (БЖИ) тооцов. Насанд хүрэгчдийн БЖИ-ээр тухайн өрхийн хоол тэжээлийн байдлыг төлөөлөн илэрхийлэх боломжтой гэж суурь судалгаанд үзсэнийг эцсийн судалгаанд мөн ашиглав. ОХЯИ нь илүүдэл жинтэй насанд хүрэгчид болон хүүхдүүдийг хоол тэжээлийн дутагдалд орсонд тооцдоггүй. Насанд хүрэгчдийн БЖИ 18.5-аас доош бол хоол тэжээлийн дутагдалд орсон гэж үзнэ. Зураг 12-д суурь судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн БЖИ-ээр илэрхийлсэн эрүүл мэндийн байдлыг үзүүлэв.

Зураг 12. Өрх тус бүрийн гишүүдийн БЖИ, %, N=181



БЖИ-ийн үзүүлэлтээс харахад оролцогчдын 40.39% нь жингийн илүүдэлтэй, таргалалттай байна. БЖИ-ийн үзүүлэлтээр нийт өрхийн 51.9% эрүүл байна. Түүнчлэн суурь судалгаанд нийт иргэдийн 7.2% туранхай буюу хоол тэжээлийн хомсдолд орсон гэж үнэлэгджээ.


Өрхийн амьдралын нөхцөл

ОХЯИ нь амьдралын нөхцөлийг тодорхойлоход зургаан шалгуур үзүүлэлтийг авч үздэг байна. Үүнээс гурван индикатор нь өрхийн гишүүдийн өдөр тутмын амьдралд илүү нөлөөлдөг хүчин зүйлс болох ундны цэвэр ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж, цэвэр түлшний хэрэглээ зэрэг эрүүл мэнд болон амьжиргааны түвшинтэй холбоотой байдаг. Хоёр индикаторт нь өрхийн орон сууцны чанарыг суурь түвшинд харуулахуйц цахилгаан эрчим хүч болон цахилгаан хангамжийн төрөл, шалны материалын хүртээмж зэрэг багтдаг. Сүүлчийн индикатор нь радио, зурагт, утас, унадаг дугуй,

мотоцикл, суудлын болон ачааны машин, хөргөгч зэрэг өмч хөрөнгийг орлуулан тооцох боломжтой өргөн хэрэглээний бараануудыг (Alkire Sabina, et al., 2011) багтааж авч үздэг байна.


Амьдарч буй сууц, түүний нөхцөл: Суурь судалгаанд оролцсон өрхийн дийлэнх (94.2%) нь гэр, 4.3% нь байшин, 1.4% нь нийтийн байранд амьдарч байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн амьдарч буй сууцны төрөлд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 13-нд сууцны төрлийг байршлаар ялган харууллаа. Зорилтот 5 байршлын хувьд харьцангуй өндөр ялгаа ажиглагдсангүй. Тухайлбал, гэр сууцанд амьдардаг өрх зорилтот 5 байршилд 92 ба түүнээс дээш хувьтай, байшин сууцанд амьдардаг өрхийн хувьд 6-7 хувьтай байна. Харин нийтийн байранд амьдарч буй өрхийн хувьд зөвхөн нэг байршил буюу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгон 6.3%-тай байна.

Зураг 13. Өрхийн амьдарч буй сууцны төрөл, зорилтот байршлаар, %, N=69



Үндсэн сууцны шалны үндсэн материалыг тодруулахад судалгаанд оролцогч нийт 69 өрхийн 82.4% нь шалгүй буюу нягтаршуулсан шороо эсвэл аргал дэвссэн шалтай байна. Үүнтэй холбоотойгоор өрхийн 82.4% нь амьжиргааны түвшний индикаторын шалны үзүүлэлтийн хувьд¹ гачигдал хомсдолтой байна.


Зураг 14. Өрхийн сууцны шалны үндсэн материал, байршлаар, %, N=69



Өрхийн амьдарч буй нөхцөлийг суурь судалгаанд оролцогчдоор үнэлүүлэхэд харьцангуй өндөр буюу 76.8% нь сайн, маш сайн гэсэн үнэлгээг өгсөн бол муу гэсэн үнэлгээг 5.8% нь өгсөн байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн амьдарч буй сууцны төрөлд ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 15-нд сууцны төрлийг байршлаар ялган харууллаа.

¹ 1 Монголчуудын уламжлалт амьдралын хэв маягтай холбоотой

Зураг 15. Өрхийн амьдарч буй сууцны нөхцөл, зорилтот байршлаар, %, N=69



Цахилгаан, эрчим хүч: Суурь судалгаанд оролцсон нийт өрхөөс нэг өрхөөс бусад нь буюу 98.5% нь цахилгааны хангамжтай байна. Тэдний 5.9% нь төвлөрсөн цахилгааны системд, 1.5% дизель станц, бензинээр ажилладаг генератор, 88.2% нь нарны эрчим хүч, 2.9% бага оврын цахилгаан үүсгүүр тус тус ашигладаг байна. Эндээс харахад суурь судалгаанд нэг өрх амьжиргааны түвшний индикаторын тог цахилгааны үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой гарсан байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 16-нд цахилгаан, эрчим хүчний эх үүсвэрийг байршлаар ялган харууллаа. Зорилтот 5 байршлын хувьд харьцангуй өндөр ялгаа ажиглагдсангүй. Тухайлбал, зорилтот 5 байршилд нарны эрчим хүчний үүсвэртэй өрх 70 ба түүнээс дээш хувьтай байна. Харин Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны нэг өрх ямар нэгэн эрчим хүчний эх үүсвэргүй гэж хариулжээ.

Зураг 16. Өрхийн цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=69




Ундны цэвэр ус: Ундны цэвэр усны гол эх үүсвэрийн хувьд суурь судалгаанд оролцсон нийт өрхийн дийлэнх буюу 89.7% нь хамгаалагдсан худаг ашиглаж байна. Харин 2.9% нь хамгаалагдсан булаг шанд, 4.4% нь зөөврийн усны үйлчилгээ, 3% буюу хоёр өрх нь гадаргын буюу гол, мөрөн болон борооны усыг ашигладаг байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн ундны цэвэр усны гол эх үүсвэрт ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 17-нд ундны цэвэр усны эх үүсвэрийг байршлаар ялган харууллаа. Зорилтот 5 байршлын хувьд харьцангуй өндөр ялгаа ажиглагдсангүй. Тухайлбал, зорилтот 5 байршилд хамгаалагдсан худаг ашигладаг өрх 78 ба түүнээс дээш хувьтай байна. Харин Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт багийн нэг өрх борооны ус, Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн багийн нэг өрх гадаргын ус ашиглаж байна.

Зураг 17. Өрхийн ундны усны гол эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=69



Ундны цэвэр усны хүртээмжийн хувьд цэвэр усаар хангагдаагүй болон цэвэр ус авахаар гэрээсээ гарахад 30-аас дээш минут зарцуулах шаардлага гардаг бол цэвэр усны хомсдолтойд тооцдог. Ундны цэвэр усанд хоолойн ус, нийтийн цорго, цооног, шахуурга, хамгаалалттай худаг, хамгаалагдсан булаг шанд зэрэг ордог. Өрхийн 46.8% нь цэвэр ус хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, үлдсэн 53.3% нь ундны усны үзүүлэлтээр хангалтгүй буюу хомсдолтой байна.

Зураг 18. Ундны цэвэр усны үүсвэрт хүрэх хугацаа, %, N=69



Ариун цэврийн нөхцөл байдал: Тухайн өрх шаардлага хангасан ариун цэврийн байгууламжгүй эсвэл бие засах газар нь дундынх бол сайжруулсан ариун цэврийн байгууламжийн дутагдалтай гэж үздэг. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид татуургатай суултуурын болон явган жорлон, бусадтай тухайн нэг өрх гишүүд л хэрэглэдэг, агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон зэрэг орно. Үүнээс гадна өрх өөрсдийн нөхцөл байдалд сэтгэл ханамжгүй тохиолдолд үүнийг ариун цэврийн гачигдал дутагдалтайд тооцно. Босго шугамын дагуу суурь судалгаанд өрхүүдийн зөвхөн 19.1% нь сайжруулсан ариун цэврийн байгууламжийг ашиглаж байгаа бол үлдсэн 80.8% нь нийтийн болон ямар нэгэн ариун цэврийн байгууламжгүй байна. Тодруулбал, суурь судалгаанд оролцсон өрхийн 80.8% нь амьжиргааны түвшний индикаторын ариун цэврийн үзүүлэлтийн хувьд гачигдал хомсдолтой байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн ариун цэврийн байгууламжид ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 19-нд өрхийн ариун цэврийн байгууламжийн төрлийг байршлаар ялган харууллаа. Таван зорилтот байршлын хувьд дийлэнх буюу 60 ба түүнээс дээш хувь нь ариун цэврийн байгууламжгүй гэж хариулсан байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт багийн судалгаанд оролцогч өрхүүд харьцангуй өндөр буюу 93.3% нь ариун цэврийн байгууламжгүй байна.


² Монголчуудын уламжлалт амьдралын хэв маягтай холбоотойгоор ариун цэврийн байгууламж ашигладаггүй болно.

Зураг 19. Өрхийн бие засах газрын төрөл, зорилтот байршлаар, %



Дулаан хангамжийн нөхцөл байдал: Тухайн өрх мод, нүүрс эсвэл аргал түлдэг бол цэвэр түлшний гачигдал хомсдолтойд тооцогддог. Өрхүүдийн дийлэнх нь ердийн галлагаа болох мод, бууцаар дулааны хангамжаа бүрдүүлж байна. Суурь судалгаанд оролцсон өрхийн 82.6% нь цэвэр түлшний үзүүлэлтийн хувьд хомсдолтой байна. Төслийн зорилтот байршлаар өрхийн дулаан хангамжийн эх үүсвэрт ялгаа байгаа эсэхийг харах зорилгоор Зураг 20-нд дулаан хангамжийн эх үүсвэрийг байршлаар ялган харууллаа. Зорилтод 5 байршлын хувьд түлшиндээ аргал, хөрзөн (бууц) харьцангуй өндөр хэрэглэж байгаа нь Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт баг (56.0%), Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгон (56.5%) байна.

Зураг 20. Дулаан хангамжийн эх үүсвэр, зорилтот байршлаар, %, N=69



Өмч хөрөнгийн эзэмшил: Өрхүүд нэгээс дээш тооны радио, зурагт, утас, унадаг дугуй, мотоцикл, хөргөгч, угаалгын машин, мөнгөн аяга, эсвэл ногооны хүлэмж (машин эсвэл тракторгүй) эзэмшдэггүй

бол өмч хөрөнгийн гачигдал хомсдолтойд тооцогддог. Ихэнх өрх нэгээс олон тооны өргөн хэрэглээний бараа эзэмшиж байна. Өрхүүдийн хамгийн их эзэмшиж байсан бараанд гар утас, зурагт, угаалгын машин, хөргөгч дөрөв багтаж байна.

Зураг 21. Ахуйн өргөн хэрэглээний эд зүйлстэй өрх, N=69



Мөн нийт суурь судалгаанд оролцогч өрхөөс эзэмшиж буй тээврийн хэрэгслийг тодруулахад өрхүүдийн дийлэнх буюу 95.7% нь мотоциклтой байгаа бол 60.9% нь суудлын автомашин, 43.5% нь ачааны машинтай, 4.3% нь хөсөг тэрэгтэй байна.

Зураг 22. Тээврийн хэрэгсэлтэй өрх, %, N=69



ОХЯИ-ийн амьдралын нөхцөлийг тодорхойлоход ашигладаг үндсэн зургаан индикаторын нэг болох өмч хөрөнгийн эзэмшлийн шалгуурт суурь судалгааны оролцогч өрхүүдийн хувьд өмч хөрөнгийн гачигдал хомсдолгүй байлаа.


Өрхийн аж ахуй болон эдийн засгийн зарим үзүүлэлт, түүнд гарсан өөрчлөлт

Өрхийн аж байдал

Говийн их дархан цаазат газрын малчин өрхийн нийгэм эдийн засгийн шинж байдал, түүний өөрчлөлтийг энэхүү бүлэгт харууллаа. Өөрчлөлтийг харуулахдаа сүүлийн 2-3 жилээр харьцуулан харуулсан ба өрхийн амьжиргааны нөхцөл байдал, өрхийн аж ахуй эрхлэлт, өрхийн орлого зарлага, хадгаламж ба зээлийн шинж байдал гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр хэмжсэн.


Судалгаанд хамрагдсан нийт өрхөөс өөрсдийгөө амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдралтай гэж үзсэн өрх байхгүй байсан. Нийт өрхийн 5.8% нь өөрсдийгөө дундаас доогуур давхраанд, 59.4% нь дунд, 31.9% нь дундаас дээгүүр, 2.9% дээгүүр давхраанд хамаарна гэж үзсэн байна.

Зураг 23. Өрхийн нийгмийн аж байдлын түвшин, %, /өөрийн субъектив үнэлгээгээр/



Сүүлийн 2-3 жилийн амьжиргааны түвшний өөрчлөлтийн хувьд нийт өрхийн 2.9% нь бүр дордсон, 23.2% нь бага зэрэг доошилсон, 43.5% нь хэвэндээ, 18.8% нь бага зэрэг дээшилсэн, 11.6% нь мэдэгдэхүйц дээшилсэн гэж үзсэн байна. Зорилтот аймгийн багаар нь амьжиргааны түвшний өөрчлөлтийг харьцуулан харвал Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Идрэн багийн 14 өрхийн 14.3% нь амьжиргааны түвшнээ бүр дордсон гэж үзсэн ба бусад багуудад бүр дордсон гэж үзсэн өрх байхгүй байна. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол багийн 78.6%, Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт багийн 20% нь амьжиргаагаа бага зэрэг доошилсон гэж үзсэн байна. Амьжиргааны түвшнээ дордсон гэж үзсэн өрхүүдийн дийлэнх нь Баянхонгор аймгийн зорилтот сумдын багуудын өрхүүд байна. Энэ нь магадгүй Баянхонгор аймагт сүүлийн жилүүдэд ган зуд тохиолдсонтой холбоотой байж болно.

Зураг 24. Өрхийн амьдралын түвшний өөрчлөлт/төслийн зорилтот багаар/, %



Өрхийн эрхэлж байгаа үйл ажиллагааны хувьд давхардсан тоогоор авч үзвэл нийт өрхийн 7.2% нь газар тариалан, 100.0% нь мал аж ахуй, 1.4% туслах аж ахуй, 2.9% нь бичил уул уурхайн аж ахуй эрхэлж байна. Нийт өрхийн 88.4% нь 1 төрлийн үйл ажиллагаа, 11.6% нь 2 төрлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Аж ахуй эрхлэлтийн байдлыг зорилтот багаар харьцуулан харвал газар тариаланг Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн өрхүүд эрхэлж байгаа бол, бичил уул уурхай, туслах аж ахуйг Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын багуудын өрхүүд эрхэлж байна.

Хүснэгт 4. Өрхийн эрхэлдэг аж ахуйн төрөл/давхардсан тоогоор, зорилтот багаар/, %

Нийт судалгаанд хамрагдсан өрхийн хувь	Судалгаанд оролцогчдын тоо	Өрхийн харьяалал				
		Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг
Нийт судалгаанд хамрагдсан өрхийн тоо	69	14	14	10	16	15
Өрхийн аж ахуй эрхлэлт						
Газар тариалан	7.2%	0.0%	0.0%	0.0%	31.3%	0.0%
Мал аж ахуй	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Туслах аж ахуй	1.4%	7.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Бичил уул уурхай	2.9%	7.1%	7.1%	0.0%	0.0%	0.0%

Судалгаанд оролцогч нийт өрхийн орлого олдог гишүүдийн тоог авч үзвэл дийлэнх буюу 81.1% нь 2 гишүүн хөдөлмөр эрхэлж байна. 3 болон түүнээс дээш орлого олдог гишүүн 13%, 1 гишүүн орлого олдог өрх 5.8% эзэлж байна. Харин эмэгтэй орлого олдог гишүүдээр нь харахад 5.8% нь огт хөдөлмөр эрхэлдэггүй, 91.3% нь 1 эмэгтэй гишүүн, 2.9% нь 2 эмэгтэй гишүүн хөдөлмөр эрхэлж байна. Нийт 69 өрхийн 65 буюу 94% нь орлого олдог эмэгтэй гишүүнтэй байна.

Хүснэгт 5. Орлого олдог гишүүдийн тоо /байршлаар/, %

	Нийт өрхийн хувь	Өрхийн харьяалал, хаяг				
		Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг
Нийт өрхийн тоо	69	14	14	10	16	15
Нийт орлого олдог гишүүдийн тоо						
1	5.80%	14.3%	7.1%	0.0%	6.3%	0.0%
2	81.20%	64.3%	85.7%	100.0%	75.0%	86.7%
3	10.10%	14.3%	7.1%	0.0%	18.8%	6.7%
4	2.90%	7.1%	0.0%	0.0%	0.0%	6.7%
Эмэгтэй орлого олдог гишүүдийн тоо						
Эмэгтэй гишүүн ажил эрхэлдэггүй	5.80%	21.4%	7.1%	0.0%	0.0%	0.0%
1	91.30%	71.4%	85.7%	100.0%	100.0%	100.0%
2	2.90%	7.1%	7.1%	0.0%	0.0%	0.0%

Нийт өрхөд 145 хөдөлмөр эрхэлдэг гишүүн байгаагаас 67 нь эмэгтэй гишүүд байна. Эмэгтэй гишүүдийн жилийн дундаж орлого 10,274,082 төгрөг байгаа ба эрэгтэй гишүүдийн жилийн дундаж орлогоос 11,8%-аар бага байна.

Хүснэгт 6. Орлогын эх сурвалж ба хөдөлмөр эрхлэлтийн байдал

Нийт орлого олдог гишүүдийн тоо	Эмэгтэй орлого олдог гишүүдийн тоо	Нийт орлогын эх сурвалжийн тоо	Эмэгтэй гишүүдийн орлогын эх үүсвэр	Эрэгтэй гишүүдийн жилийн дундаж орлого	Эмэгтэй гишүүдийн жилийн дундаж орлого	Эмэгтэй орлого олдог гишүүдийн орлогын зөрүү
145	67	117	77	11,486,208 төгрөг	10,274,082 төгрөг	1,212,126 төгрөг


Эмзэг бүлгийн гишүүнтэй өрхийн жилийн дундаж орлого эмзэг бүлгийн гишүүнгүй өрхөөс 231,097 төгрөгөөр илүү байгаа бол харин ядууралд өртсөн өрхийн жилийн дундаж орлого ядууралд өртөөгүй өрхийн орлогоос 3,633,184 төгрөгөөр бага байна. Хэдий тухайн өрхөд эмзэг бүлгийн гишүүн байдаг ч орлогын хувьд эмзэг бүлгийн гишүүнгүй өрхөөс орлого нь өндөр байна.

Хүснэгт 7. Эмзэг болон ядуу өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр

	Эмзэг бүлгийн гишүүнтэй өрх	Эмзэг бүлгийн гишүүнгүй өрх	Ядууралд өртсөн өрх	Ядууралд өртөөгүй өрх
Өрхийн жилийн нийт орлого (төгрөгөөр)	21,954,545 төгрөг	21,723,448 төгрөг	19,853,665 төгрөг	23,486,849 төгрөг

2019 онд нийт өрхийн 7.2% нь 1 гишүүн орлого олдог, 78.3% нь 2 гишүүн орлого олдог, 14.4% нь 3 ба түүнээс дээш гишүүн орлого олдог байсан бол 2020 болон 2021 онд 1 гишүүн орлого олдог өрх 5.8%, 3 ба түүнээс дээш гишүүн орлого олдог өрх 13.0% болж буурсан, 2 гишүүн орлого олдог өрх 81.2% болж 2020 онтой ижил, 2019 оноос өссөн байна шинж байдалтай байна. 2020 болон 2021 онд өрхийн орлого олдог гишүүдийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

Зураг 25. Орлого олдог гишүүдийн тоо, %,



Өрхийн орлого, зарлага

Зорилтот бүс нутгуудын жилийн дундаж орлогыг улсын жилийн дундаж орлоготой харьцуулан харахад 2020 онд улсын дундаж орлого 18,106,044 байгаа ба зорилтот бүс нутгын өрхүүдийн орлого улсын дундаж орлогоос 10.6%-аар илүү байна. 2020 онд өрхийн жилийн дундаж орлого 20,032,941 төгрөг байсан бол 2021 онд 21,760,290 төгрөг болж өмнөх оны жилийн орлоготой харьцуулахад 8.6% өссөн байна. Ноос ноолуурын орлого 2020 онтой харьцуулахад 2021 онд 23.5% өссөн нь өрхийн нийт орлого өсөхөд гол нөлөөлсөн байна. Мал зарах, малын махнаас олох орлого 2020 онтой харьцуулахад 7.5%, нийгмийн халамж тэтгэвэр тэтгэмжийн орлого 4.4% буурсан байна. 2021 онд бичил уул уурхайгаас орлого олох орлогын төрөл нэмэгдсэн ба дунджаар 50,000 төгрөгийн орлого олсон байна.

Хүснэгт 8. Өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр, /оноор/

Орлогын төрлүүд	2020 он	2021 он	Өсөлтийн хувь
Улсын дундаж орлого	18,106,044	N/A	N/A
Өрхийн жилийн нийт орлого (төгрөгөөр)	20,032,941	21,760,290	8.6
Ноолуураас олсон жилийн дундаж орлого	13,746,269	16,977,612	23.5
Мал (зарах) махнаас олсон жилийн дундаж орлого	6,630,000	6,131,818	-7.5
Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн жилийн дундаж орлого	4,076,600	3,897,885	-4.4
Бичил уул уурхайгаас олсон жилийн нийт орлого	-	50,000	-

Өрхийн жилийн дундаж орлогыг зорилтот багаар харьцуулан харвал Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын зорилтот багуудад өрхийн жилийн дундаж орлого өмнөх онтой харьцуулбал хамгийн өндөр өсөлттэй байна. Өмнөх онтой харьцуулахад Баян-Өндөр сумын Идрэн багийн өрхийн жилийн дундаж 16.6%, Шинэжинст сумын Уртын голын багын жилийн дундаж орлого 17.9% өссөн байна. Говь-Алтай аймгийн зорилтот багуудын хувьд Баянтоорой тосгон болон Өлзийт багуудад өрхийн жилийн орлого өмнөх онтой харьцуулахад 6%-10%-ийн өсөлттэй байгаа бол Алтай сумын Урт багын өрхийн жилийн дундаж орлого 4.6% буурсан байдалтай байна. Баянхонгор аймгийн зорилтот багуудын жилийн дундаж орлого улсын дундаж орлогоос доогуур байгаа бол Говь-Алтай аймгийн зорилтот багийн жилийн дундаж орлого улсын жилийн дундаж орлогоос дээгүүр байна. Тодруулбал Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн багийн өрхийн жилийн дундаж орлого улсын


жилийн дундаж орлогоос 0.74%-аар бага, Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол багийн өрхүүдийн жилийн дундаж орлого 32.7%-аар бага байна.

Хүснэгт 9. Өрхийн жилийн дундаж орлого, мөнгөн дүнгээр, /зорилтот багаар/

Өрхийн харьяалал, хаяг	2020 оны жилийн дундаж орлого	2021 оны жилийн дундаж орлого	Өсөлт / бууралтын хувь
Улсын дундаж орлого	18,106,044	N/A	N/A
Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	17,972,143	20,957,857	16.6
Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	12,178,571	14,364,286	17.9
Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	30,390,000	29,000,000	-4.6
Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	19,958,750	22,140,625	10.9
Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг	22,635,000	24,180,000	6.8

2020 онд нийт өрхийн 11.6% нь 5 сая хүртэл, 14.5% нь 5-10 сая, 24.6% нь 10-20 сая, 21.7% нь 20-30 сая, 17.4% нь 30-40 сая, 10.1% нь 40 ба түүнээс дээш сая төгрөгийн жилийн орлоготой байна. 2021 онд 30 хүртэл сая төгрөгтэй өрхийн хувь өссөн бол 30-40 саяын орлоготой өрхийн хувь буурсан байна.

Зураг 26. Өрхийн жилийн орлогын бүлэг/нийт өрхөд эзлэх/, %



Өрхийн орлогын бүлгийг зорилтот багаар харьцуулан харвал Баянхонгор аймгийн зорилтот багуудад 30 саяас дээш орлоготой өрхийн эзлэх хувь өссөн байдалтай байна. Говь-Алтай аймгийн Алтай сумын Уртын баг, Эрдэнэ сумын Өлзийт багуудад 40 ба түүнээс дээш сая орлоготой өрхийн эзлэх хувь буурсан байна.

Хүснэгт 10. Өрхийн орлогын бүлэг /зорилтот багаар, %/

	Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг
Нийт өрхийн тоо	14	14	10	16	15
2020 оны жилийн нийт орлого					

1-5 сая	7.1%	14.3%	0.0%	25.0%	20.0%
5-10 сая	7.1%	42.9%	10.0%	12.5%	6.7%
10-20 сая	42.9%	28.6%	30.0%	18.8%	26.7%
20-30 сая	42.9%	14.3%	30.0%	12.5%	20.0%
30-40 сая	0.0%	0.0%	0.0%	18.8%	13.3%
40 ба түүнээс дээш сая	0.0%	0.0%	30.0%	12.5%	13.3%
2021 оны жилийн нийт орлого					
1-5 сая	7.1%	14.3%	0.0%	18.8%	13.3%
5-10 сая	7.1%	35.7%	10.0%	6.3%	13.3%
10-20 сая	28.6%	28.6%	40.0%	18.8%	13.3%
20-30 сая	35.7%	7.1%	20.0%	31.3%	13.3%
30-40 сая	14.3%	14.3%	20.0%	12.5%	26.7%
40 ба түүнээс дээш сая	7.1%	0.0%	10.0%	12.5%	20.0%


Өрхийн жилийн дундаж зарлага 2020 онд 9,930,333 төгрөг байсан бол 2021 онд 10,691,893 төгрөг болж 2020 онтой харьцуулахад 761,559 төгрөгөөр буюу 7.7% өссөн байна. Зардлын өсөлтийг зардлын төрлөөр харьцуулан харвал өрхийн хүнсэндээ зарцуулдаг жилийн дундаж зардал 2020 онтой харьцуулахад 2021 онд 59.5% буюу 1,511,811 төгрөгөөр буурсан, бензин түлшиндээ зарцуулдаг жилийн дундаж зардал 2020 онтой харьцуулахад 2021 онд 25.1% буюу 942,681 төгрөгөөр буурсан байна. Өрхийн баяр наадамд зарцуулдаг зардал 2020 онтой харьцуулахад 2021 онд 46.1% буюу 1,189,863 төгрөгөөр өссөн, малын тэжээл, нүүдлийн зардал 2020 онтой харьцуулахад 2021 онд 134.3 буюу 1.603.043 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Өрхийн жилийн дундаж зардал, мөнгөн дүнгээр- мнт, /оноор/

	2020 он (жилээр, мөнгөн дүнгээр)	2021 он (жилээр, мөнгөн дүнгээр)	Өсөлт/ бууралтын хувь
Жилийн нийт зарлага	9,930,333	10,691,893	7.7
Хүнсний жилийн нийт зарлага	2,540,580	1,028,768	-59.5
Бензин түлшний нийт зарлага	3,760,507	2,817,826	-25.1
Баяр наадмын жилийн нийт зарлага	2,582,609	3,772,472	46.1
Малын тэжээл, нүүдлийн зарлага	1,194,058	2,797,101	134.3

2020 онд нийт өрхийн 27.5% нь 5 сая хүртэл, 37.7% нь 5-10 сая, 34.8% нь 10-аас дээш сая төгрөгийн зардал гаргасан байна. 2021 онд 5 хүртэл сая төгрөгийн зардал 21.7% болж 5.8%-аар буурсан, 10-аас дээш сая төгрөгийн зардал гаргасан өрхийн хувь 5.8%-аар өссөн байна.

Зураг 27. Өрхийн жилийн нийт зарлага, %, /оноор/



Зарлагыг зорилтот багаар харьцуулан харвал Судалгааны бүх зорилтот багуудын хувьд 2020 онтой харьцуулахад 2021 онд өрхийн зарлага өссөн байдалтай байна. Нийт өрхөд эзлэх 10 саяас их орлоготой өрхийн хувь өссөн шинжтэй, 5 сая хүртэл орлоготой өрхийн эзлэх хувь буурсан шинжтэй байна.

Хүснэгт 12. Өрхийн жилийн зарлага, %, /зорилтот сумаар/

	Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг
Нийт өрхийн тоо	14	14	10	16	15
2020 оны жилийн нийт зарлага					
5 сая хүртэл	28.6%	28.6%	0.0%	37.5%	33.3%
5-10 сая	28.6%	42.9%	40.0%	31.3%	46.7%
10 саяас их	42.9%	28.6%	60.0%	31.3%	20.0%
2021 оны жилийн нийт зарлага					
5 сая хүртэл	14.3%	21.4%	0.0%	31.3%	33.3%
5-10 сая	50.0%	35.7%	50.0%	31.3%	26.7%
10 саяас их	35.7%	42.9%	50.0%	37.5%	40.0%

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн олж буй орлогын хүрэлцээг нь харвал нийт өрхийн 11.6% нь өдөр тутмын суурь хэрэгцээнд ч хүрэлцдэггүй, 18.8% нь өдөр тутмын суурь хэрэгцээндээ л хүрэлцдэг, 40.6% Өдөр тутмын хэрэгцээгээ хангаад ойр зуурын хувцас хунар зэрэгт л хүрэлцдэг, 7.2% нь үнэ цэнтэй зүйл авч хүрэлцдэг, 21.7% нь хэрэгцээнээсээ илүүчилж хуримтлуулж чаддаг гэж үзсэн байна. Өрхийн орлогын хүрэлцээ Говь-Алтай аймгийн зорилтот багуудаас судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд сайн байгаа ба Баянхонгор аймгийн зорилтот багуудын хувьд Идрэн багаас судалгаанд хамрагдсан өрхүүдийн 28.6% нь, Уртын гол багийн 14.3% өдөр тутмын суурь хэрэгцээндээ хүрдэггүй гэж үзсэн байгаа нь зорилтот багууд дотроо хамгийн өндөр хувьтай байна. Орлогын хүрэлцээний нөхцөл байдлыг дундаж орлоготой харьцуулан харвал жилийн дундаж орлого бага Баянхонгор аймгийн багуудад өдөр тутмын суурь хэрэгцээнд хүрэлцэхгүй байдал хамгийн өндөр байна. Баянхонгор аймгийн зорилтот багуудын орлого 2020 онтой харьцуулахад 2021 онд өсөлттэй гарсан боловч ерөнхий дундаж орлого Говь-Алтай аймгийн зорилтот багуудын дундаж орлогоос доогуур байна.

Зураг 28. Өрхийн орлогын хүрэлцээ, %, /зорилтот багаар/



Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 31.9% нь хадгаламжтай өрх байна. Хадгаламжтай өрхийг зорилтот багаар харьцуулан харвал Говь-Алтай аймгийн зорилтот баг болох Урт баг болон Өлзийт багуудаас хамрагдсан нийт өрхийн 50.0% ба түүнээс дээш хувь нь хадгаламжтай байгаа нь бусад багуудаасаа хамгийн өндөр нь байна. Хадгаламжтай өрхийн хувь Баянхонгор аймгийн Идрэн баг болон Говь-Алтай аймгийн Баянтоорой багуудад хамгийн бага байна.

Хүснэгт 13. Өрхийн хадгаламж, %, /зорилтот багаар/

Хадгаламжтай өрхийн хувь	Нийт өрхийн тоо	Хадгаламжтай өрхийн хувь	Хадгаламжтай өрхийн тоо
Нийт хадгаламжтай өрхийн хувь	69	31.9%	22
Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	14	14.3%	2
Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	14	28.6%	4
Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	10	50.0%	5
Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	16	18.8%	3
Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг	15	53.3%	8

Нийт өрхийн 53.6% нь 2020 онд зээлтэй байсан бол 2021 онд 62.3% болж өмнөх онтой харьцуулахад 8.3%-аар өссөн байна. Баянхонгор аймгийн зорилтот багуудад 2021 онд нэмж өрхүүд зээл аваагүй байдалтай байгаа бол зээлтэй өрхийн тоо өсөхөд Говь-Алтай аймгийн зорилтот багуудын зээлтэй өрхүүдийн тоо нэмэгдсэн байдал нөлөөлсөн байна.

Хүснэгт 14. Өрхийн зээл, %, /зорилтот бүлгээр/

	Нийт өрхийн хувь	Баянхонгор аймаг, Баян- Өндөр сум, Идрэн баг	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг
Нийт өрхийн тоо	69	14	14	10	16	15
2020 онд зээлтэй өрхийн хувь	53.6%	64.3%	71.4%	40.0%	68.8%	20.0%
2021 онд зээлтэй өрхийн хувь	62.3%	78.6%	71.4%	50.0%	81.3%	26.7%

Нийт өрхийн ердөө 2.9% нь нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагдсан байгаа ба эдгээр хамрагдсан өрхүүд бүгд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт багийн өрхүүд байна.

Орлого зарлагаа тэмдэглэж эдийн засгийн тооцоо хийх байдал нийт өрхийн 23.2% нь хийж байгаа ба Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол багын өрхүүдийн 35.7% нь мөн орлого зарлагаа тэмдэглэдэг нь бусад багууд дундаа хамгийн өндөр үзүүлэлт байна.

Хүснэгт 15. Өрхийн эдийн засгийн идэвхжилтийн байдал, %, /зорилтот багаар/

	Нийт өрхийн хувь	Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	Говь- Алтай аймаг, Алтай сум, Урт баг	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	Говь- Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг
Нийт өрхийн тоо	69	14	14	10	16	15
Нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагдсан өрхийн хувь	2.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	13.3%
Орлого зарлагаа тэмдэглэж эдийн засгийн тооцоо хийдэг өрхийн хувь	23.2%	21.4%	35.7%	20.0%	25.0%	13.3%

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 3.0% нь амьдралдаа сэтгэл ханамжгүй, 11.9% нь дунд зэрэг сэтгэл ханамжтай, 49.3% нь сэтгэл ханамжтай, 35.8% нь маш их сэтгэл ханамжтай байдаг гэж хариулсан байна.

Сэтгэл ханамжийг зорилтот багуудаар харьцуулан харвал Говь-Алтай аймгийн зорилтот багуудад амьдралын сэтгэл ханамж хамгийн өндөр байгаа ба Эрдэнэ сумын Өлзийт багийн 74.1%, Цогт сумын Баянтоорой тосгоны 37.5%, Алтай сумын Уртын багийн 40.0% нь амьдралдаа маш их сэтгэл ханамжтай байдаг гэж хариулсан байна.

Зураг 29. Амьдралын сэтгэл ханамж, %, /зорилтот багаар/



Олон хэмжээст ядуурлын индекс³

Суурь судалгааны хүрээнд 5 багийн 69 өрхийн түүвэр өгөгдлийг ашиглан олон хэмжээс ядуурлын индексийг тооцлоо. Уг индекс тооцоололд аргачлалын дагуу боловсрол (суралцсан жил, сургуульд хамрагдалт), эрүүл мэнд (нялхсын эндэгдэл, хоол хүнсний шим тэжээл), амьжиргааны түвшин (цахилгаан, ундны ус, ариун цэврийн нөхцөл, гэр, байр, орон сууцны шал, хоол унд хийх түлш, өмч хөрөнгийн эзэмшил) гэсэн 3 бүлэг, 10 дэд үзүүлэлтийг түүврийн асуулгын харгалзах асуултуудад үндэслэн 0, 1 гэсэн утга оноон, кодолж, тухайн өрхийн ядууралд өртсөн эсэхийг ядуурлын оноог (deprivation score) тооцох замаар тодорхойлов.

Нийт өрхийн 33.3% нь суралцах хугацааны дундаж жилийг илэрхийлдэг индикаторт гачигдалтай, 2.9% нь сургууль завсардсан гишүүнтэй, 14.5% нь хоол хүнсний шим тэжээлийн дутагдалтай гишүүнтэй байна. Амьжиргааны түвшний индикаторын хувьд 95.7% нь ариун цэврийн нөхцөл байдлын хувьд гачигдалтай, 95.7% нь хоол ундандаа ашигладаг түлшний хувьд гачигдалтай, 87.0% нь ундны усны эх сурвалж хол зайтай эсвэл баталгаатай биш, 81.2% нь гэр орон сууцны шалны материалын хувьд гачигдалтай байна.

Хүснэгт 16. Олон хэмжээст ядуурлын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Ядууралд өртсөн өрхийн тоо	Нийт өрхөд эзлэх хувь
Боловсрол		
Суралцсан жил	23	33.3%
Сургуульд хамрагдалт	2	2.9%
Эрүүл мэнд		
Нялхсын эндэгдэл	0	0.0%
Хоол хүнсний шим тэжээл	10	14.5%
Амьжиргааны түвшин		
Цахилгаан	2	2.9%
Ундны ус	60	87.0%
Ариун цэврийн нөхцөл	66	95.7%

³ Олон хэмжээст ядуурлын индексийг тооцох аргачлалыг НҮБХХ-өөс гаргасан нийтлэг арга зүйд үндэслэн, Монгол улсын онцлог нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулсан. Монгол улсын хувьд олон хэмжээст ядуурлын индексийг тооцохдоо эрүүл мэнд, боловсрол, амьдралын нөхцөл, аж байдлын баталгаат байдал гэсэн 4 хэмжээс, тэдгээрийг тодорхойлох 10 үзүүлэлтээр тооцсон. Мэдээллийн эх үүсвэрийн хувьд Үндэсний Статистикийн Хорооноос зохион байгуулан явуулдаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг ашигласан. Дэлгэрэнгүйг: [24-2.pdf \(num.edu.mn\)](#), [Микро мэдээллийн сан \(nso.mn\)](#)

Гэр, байр, орон сууцны шал	56	81.2%
Хоол унд хийх түлш	66	95.7%
Өмч хөрөнгийн эзэмшил	0	0.0%

Олон хэмжээст ядуурлын индекс нь олон хэмжээсийн хувьд ядуу хүмүүсийн нийт хүнд эзлэх хувь (H), олон хэмжээст ядуурлын эрчимжилт (A) гэсэн хоёр индексийн үржвэрээр тодорхойлогдоно.

$$MPI = H \cdot A$$

Дээрх өрх бүрийн ядуурлын оноо, өрхийн ам бүлийн тоог тус тус ашиглан олон хэмжээст ядуурлын хамрах хүрээний индекс (H)-ийг тооцвол дараах үр дүн гарна.

$$H = q/n = 87/309 = 0.282$$

Энд n нийт хүний тоо бөгөөд өрх бүрийн ам бүлийн тооны нийлбэрээр тооцох бол q нь уг олон хэмжээст ядуурлын индексийн аргачлалын дагуу ядууралд өртсөн хүний тоо байна. Үүнийг тооцоход ядууралд өртсөн өрх бүрийн ам бүлийн тоог нэмэх замаар тооцно.

Одоо олон хэмжээст ядуурлын эрчимжилт (A)-ийг тооцъё. Үүнийг ядуурлын оноо нь $1/3$ -ээс бага байх өрхүүдийн ядуурлын оноог тэгээр засварлах замаар дараах томъёогоор уг дэд индексийг тооцоход

$$A = \left(\sum_{i=1}^n c_i(k) \right) / q = 35.33/87 = 0.406$$

гэсэн үр дүн гарна. (Энд хийгдэж буй бүх тооцооллыг SPSS 26.0 программ дээр хийсэн ба өгөгдлөөс үр дүнгийн тооцооллыг харах боломжтой.)

Дээрх хоёр дэд индексийн тооцооллын үр дүнг ашиглан эцсийн шатны судалгааны олон хэмжээст ядуурлын индексийг тооцъё.

$$MPI = H \cdot A = 0.282 \cdot 0.406 = 0.114$$

SPSS 26.0 программын өгөгдөлд дэлгэрэнгүй үр дүнг харуулсан. Олон хэмжээст ядуурлын индекс 0.114 гарсан. Тодруулбал нийт судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 28.2% ядууралд өртсөн байгаа нь Монгол улсын ядуурлын хамрах хүрээнээс 0.4%-аар өндөр байна. (2020 оны байдлаар монгол улсын ядуурлын хамрах хүрээ 27.8) Ядуурлын эрчимжилт 0.406 гарсан ба нийт ядууралд өртсөн өрхийн 40.6% нь бүх индикаторын хувьд гачигдалтай байгааг харуулж байна. Өрхийн эдийн засгийн сайн сайхан байдлын хэмжүүрийг Хүснэгт 17 -т харууллаа.

Хүснэгт 17. Эдийн засгийн сайн сайхан байдлын боломжит хэмжүүрүүд

Олон хэмжээст ядуурлын индекс	Ядуу өрхийн эзлэх хувь (H)	Ядуурлын дундаж эрчимжилт	Амьдралын сэтгэл ханамжийн дундаж утга
0.114	28.2%	40.6%	4.18

ГУРАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ БОЛОН ОРЧНЫ БҮСИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ МАЛЧДЫН ХАНДЛАГА, ОЙЛГОЛТ

4.1. Зорилт 1. ГИДЦГ-ын орчны бүсийн судалгаа, камерын хяналт, эргүүл хамгааллын тогтолцоог бэхжүүлэх

ГИДЦГ-ын орчны бүсийн малчин өрхийн байгаль хамгааллын үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд хамрагдсан эсэхийг тодруулахад 43.5% байгаль хамгааллын чиглэлийн сургалт, уулзалтад оролцсон ба нэг оролцогч дунджаар 3-4 сургалт, уулзалтад оролцсон байна. Бэлчээрийн экосистемийг сайжруулах, доройтлыг бууруулах мэдээлэл олгох сургалтад 20.3% нь хамрагдсан бол, нэг оролцогч дунджаар 3.5 удаа сургалтанд суусан байна. Байгаль хамгаалал, экосистемийн биологийн олон янз байдалд хяналт мониторинг хийх үйл ажиллагаанд 21.7% нь оролцсон бол, нэг оролцогч дунджаар 7.2 удаа тухайн үйл ажиллагаанд оролцсон байна. Үүнээс үзвэл нутгийн иргэдийн ¼ нь ямар нэг байдлаар байгаль хамгааллын үйл ажиллагаанд оролцож байна. Мөн судалгаанд хамрагдсан байршил буюу 5 багаар харьцуулж үзэхэд байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд хамрагдсан байдал төдийлөн ялгаагүй байна.

Хүснэгт 18. Байгаль хамгааллын чиглэлийн үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон байдал, %, N=69

№	Үйл ажиллагаа	Уулзалтад оролцсон хувь	Уулзалтад оролцсон дундаж тоо
1	Та байгаль хамгааллын чиглэлийн сургалт, уулзалтад оролцсон эсэх	43.5%	3.3
2	Бэлчээрийн экосистемийг сайжруулах, доройтлыг бууруулах мэдээлэл сургалт авсан	20.3%	3.5
3	Байгаль хамгаалал, экосистемийн биологийн олон янз байдалд хяналт мониторинг хийх үйл ажиллагаанд оролцсон эсэх	21.7%	7.2

Бэлчээрийн нөхцөл байдалд сүүлийн 3 жилийн хугацаанд өөрчлөлт гарсан эсэхийг тодруулахад 16.2% сайжирсан, 64.7% муудсан буюу доройтсон, 19.1% өөрчлөлт гараагүй гэсэн хариулт өгсөн. Мөн бэлчээрийн нөхцөл байдал сайжирсан хэмээн үнэлсэн оролцогчдын хувьд 7.4% их, 2.9% дунд, 5.9% бага гэсэн хариултыг өгсөн байна. Харин муудсан буюу доройтсон хэмээн үнэлсэн оролцогчдын хувьд 5.9% их, 25% дунд, 33.8% бага хэмээн тодорхойлсон байна. Мөн судалгаанд хамрагдсан байршил буюу 5 багаар харьцуулж үзэхэд бэлчээрийн нөхцөл байдал байршлаас хамаарсан ялгаагүй байна.

Хүснэгт 19. Бэлчээрийн нөхцөл байдалд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69

№	Өөрчлөлт	Сайжирсан буюу доройтсон байдлын түвшин				Нийт
		Их	Дунд	Бага	НА	
1	Сайжирсан	7.4%	2.9%	5.9%	0.0%	16.2%
2	Муудсан буюу доройтсон	5.9%	25%	33.8%	0.0%	64.7%
3	Өөрчлөлт байхгүй	0.0%	0.0%	0.0%	19.1%	19.1%
Нийт						100%

Бэлчээрийг нөхөн сэргээх хамгаалах ажлын хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийг тодруулахад 13% сайжирсан, 13% муудсан буюу доройтсон, 74% өөрчлөлт байхгүй гэсэн хариултыг өгсөн.

Хүснэгт 20. Бэлчээрийг нөхөн сэргээх хамгаалах ажлын хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69

№	Өөрчлөлт	Сайжирсан буюу доройтсон байдлын түвшин				Нийт
		Их	Дунд	Бага	NA	
1	Сайжирсан	6%	4%	3%	0%	13%
2	Муудсан буюу доройтсон	1%	6%	6%	0%	13%
3	Өөрчлөлт байхгүй	0%	1%	0%	72%	74%
Нийт						100%

Нутгийн иргэдийн бэлчээр хамгаалах чиглэлд явуулж буй үйл ажиллагааг төрлөөр авч үзвэл 96.9% бэлчээр сэлгэн нүүдэллэх, 46.2% малын тоо толгойг бууруулах, 41.5 бэлчээрт гар худаг гаргах усжуулах, 24.6% мал тэжээх, тэжээл бэлтгэх, 13.8% булаг, шанд, өвөлжөө, хаваржааны сор газрыг хашаалах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Зураг 30. Бэлчээр хамгаалах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төрөл, %, N=69



Цаашид бэлчээрийг сэргээж хамгаалахад шаардлагатай үйл ажиллагааны чиглэлийг тодруулахад 31.3% уст цэгийн тоог нэмэгдүүлэх, худаг гаргах, 23.4% малын тоог бууруулах, чанаржуулах, 14.1% бэлчээрийг хашаалах, өнжөөх, сэлгэн нүүдэллэх, 14.1% үүлэнд нөлөөлж бороо оруулах, 6.3% уул уурхайг хориглох, 10.9% мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.

Зураг 31. Бэлчээрийг сэргээж хамгаалахад шаардлагатай үйл ажиллагааны чиглэл, %, N=69



Нутгийн иргэдийн хувьд заган ойн нөхцөл байдалд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийн авч үзвэл 8.7% сайжирсан, 55.1% муудсан буюу доройтсон, 36.2% өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 21. Заган ойн нөхцөл байдал сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69

№	Өөрчлөлт	Сайжирсан буюу доройтсон байдлын түвшин				Нийт
		Их	Дунд	Бага	NA	
1	Сайжирсан	2.9%	2.9%	2.9%	0.0%	8.7%
2	Муудсан буюу доройтсон	10.1%	26.1%	18.8%	0.0%	55.1%
3	Өөрчлөлт гараагүй	0.0%	0.0%	0.0%	36.2%	36.2%
Нийт						100%

4.2. Зорилт 2. ГИДЦГ-ын есосистемийг нөхөн сэргээх уст цэг ба амьдрах орчны менежментийн загвар гаргах

Зэрлэг амьтны тоо толгойд сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийг авч үзвэл 11.6% сайжирсан, 53.6% муудсан буюу доройтсон, 34.8% өөрчлөлт гараагүй хэмээн үзсэн байна. ГИДЦГ-ын орчны бүс нь зэрлэг амьтны тархалт өндөртэй бүс нутаг юм⁴.


Хүснэгт 22. Зэрлэг амьтны тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, %, N=69

№	Өөрчлөлт	Сайжирсан буюу доройтсон байдлын түвшин				Нийт
		Их	Дунд	Бага	NA	
1	Сайжирсан	1.4%	4.3%	5.8%	0.0%	11.6%
2	Муудсан буюу доройтсон	7.2%	13%	33.3%	0.0%	53.6%
3	Өөрчлөлт гараагүй	0.0%	0.0%	0.0%	34.8%	34.8%
Нийт						100%


Судалгааны тайлангийн энэ хэсэгт Хар сүүлт (*Gazella subgutturosa*), Хавтгай (*Camelus ferus*), Хулан (*Equus hemionus*), Цоохор ирвэс (*Panthera pardus*), Чоно (*Canis lupus*) зэрэг 5 төрлийн амьтны харагдац, харсан давтамж, харагдаж буй байршлыг авч үзсэн. Эдгээр зэрлэг амьтнаас хамгийн их харагдац сайтай нь хар сүүлт (*Gazella subgutturosa*), чоно (*Canis lupus*) байгаа бол, хамгийн харагдац муу нь ирвэс (*Panthera pardus*), хулан (*Equus hemionus*) байна.

Хар сүүлт зээрийн тухайд нутгийн иргэдийн 75.4% амьдаар нь харсан бол, 7.2% сэг зэмийг нь харсан, 17.4% огт хараагүй байна. Хар сүүлтг харсан иргэдээс харсан давтамжийг тодруулахад 1.8% жилд нэг удаа, 33.3% заримдаа (2-12 удаа), 64.9% нь ойр ойрхон буюу жилдээ 13-иас олон удаа харсан байна.

Зураг 32. Хар сүүлт харсан давтамж, %, N=57



Зураг 33. Хар сүүлт харсан байдал, %, N=69




Хавтгайны тухайд нутгийн иргэдийн 32.8% амьдаар нь харсан бол, 67.2% огт хараагүй байна. Мөн Хавтгайн сэг зэмбайгааг харсан нутгийн иргэн огт байхгүй байна. Хавтгайг харсан иргэдээс харсан


⁴ [Animals - Facts, Pictures and Resources - AZ Animals \(a-z-animals.com\)](http://a-z-animals.com)

давтамжийг тодруулахад 29.2% жилд нэг удаа, 37.5% заримдаа (2-12 удаа), 33.3% нь ойр ойрхон буюу жилдээ 13-иас олон удаа харсан байна.

Зураг 34.Хавтгай тэмээний харсан байдал, %, N=67




Зураг 35. Хавтгай тэмээ харсан давтамж, %, N=24




Хулангийн тухайд нутгийн иргэдийн 25% амьдаар нь харсан бол, 75% огт хараагүй байна. Мөн Хулангийн сэг зэм харсан нутгийн иргэн огт байхгүй байна. Хуланг харсан иргэдээс харсан давтамжийг тодруулахад 20% жилд нэг удаа, 45% заримдаа (2-12 удаа), 35% нь ойр ойрхон буюу жилдээ 13-иас олон удаа харсан байна.

Зураг 36. Хулангийн харсан байдал, %, N=68




Зураг 37. Хулан харсан давтамж, %, N=20




Ирвэсийн тухайд нутгийн иргэдийн 13.2% амьдаар нь харсан бол, 86.8% огт хараагүй байна. Мөн Ирвэсийн сэг, зэм байгааг харсан нутгийн иргэн огт байхгүй байна. Ирвэсийг харсан иргэдээс харсан давтамжийг тодруулахад 50% жилд нэг удаа, 8.3% заримдаа (2-12 удаа), 41.7% нь ойр ойрхон буюу жилдээ 13-иас олон удаа харсан байна.

Зураг 38. Ирвэсийн харсан байдал, %, N=68




Зураг 39. Ирвэс харсан давтамж, %, N=12




Чонын тухайд нутгийн иргэдийн 71.6% амьдаар нь харсан бол, 1.5% сэг зэмийг нь харсан, 26.9% огт хараагүй байна. Чоныг харсан иргэдээс харсан давтамжийг тодруулахад 16.3% жилд нэг удаа, 30.6% заримдаа (2-12 удаа), 53.1% нь ойр ойрхон буюу жилдээ 13-иас олон удаа харсан байна.

Зураг 40. Чоно харсан байдал, %, N=67



Зураг 41. Чоно харсан давтамж, %, N=49



Зэрлэг амьтад ихэвчлэн хаагуур харагдаж байгааг тодруулахад Хар сүүлт болон чоныг нутгийн иргэд олон газар харсан бол, бусад амьтадыг тодорхой нэг байршилд харсан байна. Тухайлбал **Идрэн багийн** хувьд Идрэнгийн нуруу, Шар ус, **Уртын гол багт** Цагаан богдын араар, **Урт багт** Тугалан задгай, Харын шанд, Аргалийн хар, **Баянтоорой тосгонд** Цагаан дэрс, Дээд говь, Идрэнгийн нуруу, **Өлзийт багийн хувьд** Гэрлийн хоолой, Зармангийн хоолой, Суврангийн ам, Хойд улаан, Хонгорт голлон харсан байна.

Хүснэгт 23. Зэрлэг амьтад харсан байршил,

Байршил	Хар сүүлт	Хавтгай	Хулан	Ирвэс	Чоно
Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	- Малын бэлчээрт - Зүүн, баруун нуруу - Идрэн, Идрэнгийн өвөр - Оонон хар, Бэлхий хар, Шарын уруу - Худаг - Ягаан овоо	- Идрэн - Шар ус	Идрэн	Тодорхойгүй	- Загд - Идрэн
Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	- Баянзүрх - Бор хайрхан, баруун урд - Зүрх хайрхан - Зэл элс - Хоёр худаг - Хүрэн цоо	Цагаан богдын ар	Цагаан богдын ар	Тодорхойгүй	- Цагаан богдын ар - Хайрхан
Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	- Аргалийн хар - Говь - Дов, Хармагтай - Майхан - Улаан худаг - Хар дэл, хаа сайгүй - Хар хайрхан - Хулангийн зогсоол - Шарга алтай, тахилга - Шивээт улаан	- Говь - Тугалан задгай - Харын шанд	- Говь - Тугалан задгай	- Аж богд - Аргалийн хар - Залай тавилант - Хармагтай	- Малын бэлчээрт - Ноён худаг - Хар дэл, Хар хайрхан - Харын шанд - Хоолойн ар - Шивээт
Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	- Баянтоорой, нуруунд - Говьд - Мээрэн цагаан дэрсний зоо, түнтгэр улаан овоо - Тогоон ус - Уулын бэл, Идрэнд - Хаг эрэгний талд - Хоолойд	- Говьд - Дээд говьд - Цагаан дэрс - Идрэнгийн нуруу	- Баянтоорой - Говьд - Талд	- Говьд - Ухаа - Идрэнгийн нуруунд	- Бэлчээрт - Баянтоорой - Их, бага бүтүү - Отгон - Ухаа - Идрэнгийн нуруунд
Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг	- Гэрлийн хоолой - Зарман - Зармангийн талд - Зармангийн хоолойд - Захуй зарман - Зуслан, хоолойд	- Говь, талын хар - Зармангийн хоолой - Талын хар, Сан-Уул	- Зоо - Нуруунд - Хулсан худаг - Хулсны ус	Тодорхойгүй	- Говьд - Гэрлийн хоолой - Зармангийн хоолой - Нуруунд - Суврангийн ам

		• Талын хард			• Хойд улаан • Хонгорт • Хярд
--	--	--------------	--	--	-------------------------------------

Сүүлийн 2 жилийн хугацаанд хулгайн ан, заг бэлтгэх, эмийн ургамал түүх, бичил уул уурхай эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад иргэдийн дийлэнх энэ талаар мэдлэг, мэдээлэл хомс буюу мэдэхгүй хэмээн хариулсан байна.

Хүснэгт 24. Сүүлийн 2 жилийн хугацаанд байгаль орчны зөрчилд гарсан өөрчлөлт, %, N=69

№	Төрөл	Маш их нэмэгдсэн	Нэмэгдсэн	Хэвэндэ	Багассан	Маш их багассан	Мэдэхгүй
1	Хулгайн ан	1.4%		5.8%	10.1%	4.3%	78.3%
2	Заг бэлтгэх		7.2%	26.1%	24.6%	10.1%	31.9%
3	Эмийн ургамал			5.9%	4.4%	2.9%	86.8%
4	Бичил уул уурхай	5.8%	14.5%	5.8%	8.7%	4.3%	60.9%


Байгаль орчны зөрчил голлон гарч буй саруудыг авч үзвэл зөрчлийн хэлбэрээс хамаараад ялгаатай байна. Тухайлбал хулгайн ан VIII-XI сарын хооронд буюу амьтны үс ноос ургасан, тарга авсан үед нь агнаж байгаа бол, загийг VIII-II сарын хооронд буюу сэрүүний улиралд бэлтгэж байна. Эмийн ургамалын хувьд ногоо дөнгөж ургах III-V сар болон ногоо хагдрах VIII-XI сарын хооронд түүж байна. Харин бичил уул уурхай буюу нинжагийн үйл ажиллагаанд сараас хамаарсан нөлөөлөл бага байна.

Хүснэгт 25. Байгаль орчны зөрчил голлон гарч буй сарууд, %

Сарууд	Хулгайн ан	Заг бэлтгэх	Эмийн ургамал	Бичил уул уурхай
1 сар		23.1%		7.5%
2 сар		21.7%		7.5%
3 сар			4.8%	1.5%
4 сар			9.5%	3%
5 сар			4.8%	16.4%
6 сар				16.4%
7 сар				14.9%
8 сар	20.7%	0.7%	23.8%	14.9%
9 сар	41.4%	2.1%	19%	
10 сар	31%	2.1%	19%	
11 сар	6.9%	23.8%	19%	7.5%
12 сар		26.6%		10.4%
Нийт	100%	100%	100%	100%

Байгаль орчны зөрчил гаргаж байгаа иргэдийн дийлэнх хувь нь нутгийн иргэд байна. Байгаль орчны зөрчлийг хэн үйлдэж байгааг тодруулахад хулгайн ан хийж байгаа оролцогчдын 30% нутгийн иргэд, 20% сумын төвийн иргэд, 20% аймгийн төвийн иргэд, 30% Улаанбаатар хотоос ирсэн иргэд байна. Харин заг бэлтгэж байгаа иргэдийн 69.2% нутгийн иргэд, 25% сумын төвийн иргэд, 5.8% аймгийн төвийн иргэд байна. Эмийн ургамал бэлтгэж байгаа иргэдийн 50% нутгийн иргэд, 20% сумын төвийн иргэд, 20% аймгийн төвийн иргэд, 10% Улаанбаатар хотын иргэд байна.

Зураг 42. Байгаль орчны зөрчлийг хэн үйлдэж байна, %,



Энэ хэсэгт байгаль орчны зөрчил гарч буй газруудын мэдээллийг харуулав. Эдгээр газруудын хувьд зэрлэг амьтаны харагдац ихтэй газрууд байна.

Хүснэгт 26. Байгаль орчны зөрчил гарч буй газрууд, байршлаар


Байршил	Хулгайн ан	Заг бэлтгэх	Эмийн ургамал	Уул уурхай
Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	• Баруун говь	• Идрэн	• Идрэн, хяран гүн	• Идрэн • Баруун говь • Хүрэн цав
Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	• Говьд	• 2 худаг • 2,3-р баг • Доод хоолой	• Доод хоолой • Хойд гий	• Бор хайрхан • Говь, цөл • Хүрэн цав • Цагаан дэрс
Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	• Хамгаалалтын бүс	• Өргөст, шар дээг • Шар худаг	•	• Шарга, нарийн хөх
Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	• Баянтоорой • Говьд • Өвөр бэл	• Ар хэсэг • Баянтоорой • Говьд • Хоолой • Цагаан дэрс	• Баянтоорой • Гэвш, довон адаг	• Баруун говь • Цагаан говь, тосгон • Говьд
Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг	• Идрэнгийн нуруу	• Говьд • Заган худаг • Зарман • Зармангийн хоолой • Зүүн, баруун хоолойд	• Зармангийн хоолой	• Тодорхойгүй

4.3. Зорилт 3. ГИДЦГ-ын орчны бүсийн менежментийг хэрэгжүүлэх хамтарсан засаглалын институцийг дэмжих


ГИДЦГ-ын орчны бүсийн менежментийн талаар нутгийн иргэдийг сонсож байсан эсэхийг тодруулахад 34.8% сонсож байсан бол, 65.2% сонсож байгаагүй байна. Энэ нь орчны бүсэд амьдарч байгаа иргэд ГИДЦГ-ын орчны бүсийн менежментийн талаар мэдлэг, мэдээлэл багатайг харуулж байна.

Орчны бүсэд хэрэгжиж буй үйл ажиллагаа хэр түвшинд явагдаж байгааг нутгийн иргэдээс тодруулахад 5.8% маш сайн, 15.4% сайн, 23.1% дунд зэрэг, 19.2% муу, 5.8% маш муу, 30.8% мэдэхгүй хэмээн хариулсан. Үүнээс үзвэл ГИДЦГ-ын орчны бүсийн менежментийг бэхжүүлэх чиглэлийн үйл ажиллагаа хязгаарлагдмал байна. Тухайлбал 79% нь орчны бүсийн үйл ажиллагааг дунд болон дундаас доогуур мэдэхгүй хэмээн үнэлж байна. Судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсрол зэрэг үзүүлэлтээр харьцуулаад үзэхэд төдийлөн ялгаа байхгүй байна.

Зураг 43. ГИДЦГ-ын Орчны бүсийн менежментийн талаар сонссон эсэх, %, N=69



Зураг 44. Орчны бүсэд хэрэгжиж буй үйл ажиллагаа аль хэр явагдаж байгаа эсэх, %, N=52



Нутгийн иргэдээс нутгийнхаа амьтан, ургамлын талаар мэдлэгтэй эсэхийг тодруулахад 56.5% сайн, 29% дунд, 14.5% мэдэхгүй хэмээн хариулсан. Үүнийг байршлаар ангилж харвал Идрэн, Баянтоорой, Урт багийн иргэд энэ талаарх өндөр мэдлэгтэй байгаа бол, Өлзийт, Уртын гол багийн иргэд харьцангуй сул мэдлэгтэй байна.


Зураг 45. Нутгийнхаа амьтан, ургамлын талаар мэдэх эсэх, %, N=69



4.4. Зорилт 4. Иргэдийн дунд бэлчээрийн болон сүргийн менежментээ сайжруулах, байгаль орчноо хамгаалах мэдлэг хандлагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааг нөхөрлөл болон эко-клубаар дамжуулан хийх

Орон нутгийн иргэдээс БНХМ нөхөрлөлд гишүүнчлэлтэй эсэхийг тодруулахад 24.6% нөхөрлөлд гишүүнчлэлтэй байна. Нөхөрлөлийн нэрсийг тодруулахад Идрэн залан жинст, Ирвэс, Ноолуурын хоршоо, Хайрханы ивээл, Цармын цагаан зэрэг нэрсийг нэрлэсэн. БНХМ нөхөрлөлүүдийг ямар үйл ажиллагаа явуулж байгааг тодруулахад байгаль орчин, худалдаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 46. БНХМ нөхөрлөлд гишүүнчлэлтэй эсэх, %, N=69



Нөхөрлөлийн нэрс:

- Идрэн залан жинст
- Ирвэс
- Ноолуурын хоршоо
- Хайрханы ивээл
- Цармын цагаан

Үйл ажиллагаа:

- Булгийн эх, зэрлэг амьтан хамгаалах
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэх (гар урлал)
- Ноос, ноолуур, арьс шир борлуулах
- Хурал цуглаан, тэмцээн уралдаан зохион байгуулах
- Бэлчээр ашиглалт, зохион байгуулалтыг сайжруулах


Уг орон нутагт хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудал бол усны хомсдол юм. Тухайлбал нутгийн иргэдийн 62.3% усны асуудал, 40.6% байгаль орчны доройтол, бэлчээрийн хүрэлцээ, 20.3% уул уурхай, 5.8% чоно олширч байгаа явдалд санаа зовниж байна.

Хүснэгт 27. Орон нутгийн байгаль орчинд тулгарч байгаа хамгийн хүндрэлтэй асуудлууд, байршлаар, %, N=69

№	Үйл ажиллагаа	Усны хомсдол	Уул уурхай	Байгаль орчны доройтол, бэлчээрийн хүрэлцээ	Чоно олшрох	Мэдэхгүй
1	Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Идрэн баг	35.0%	40.0%	25.0%	0.0%	0.0%
2	Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Уртын гол баг	40.9%	18.2%	40.9%	0.0%	0.0%
3	Говь-Алтай аймаг, Алтай сум, Урт баг	52.9%	0.0%	29.4%	17.6%	0.0%
4	Говь-Алтай аймаг, Цогт сум, Баянтоорой тосгон	55.6%	11.1%	27.8%	0.0%	5.6%
5	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Өлзийт баг	50.0%	0.0%	25.0%	6.3%	18.8%

Нутгийн иргэдийн хувьд байгаль орчин, цаг агаарын талаарх мэдээллийг 91.6% телевиз, 4.2% цаг уурын станц (Баянтоорой), 1.4% интернэт (Facebook), 1.4% байгаль хамгаалагч нараас мэдээлэл авч байна.

Зураг 47. Байгаль орчин, цаг агаарын мэдээлэл авч буй мэдээллийн суваг, %, N=69



Малчдын асуулга судалгаанд сурагчдын эко клубын талаар мэдээлэл аваагүй болно. Харин интернэт хайлтын судалгаагаар үзэхэд сурагчдын эко клуб сумын төвийн ЕБС-нд түшиглэн үйл ажиллагаа явуулж байна. Зорилтот 5 сумын ЕБС-ийн нийт 8 эко клубээс мэдээллээ олон нийтэд нээлттэй байрлуулсан нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЕБС-ийн “Шүхэр зүйл” эко клуб байна. Тус эко клуб 2004 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж, хүүхэд багачуудыг байгальд ээлтэй болгох боловсрол олгохоор ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг: [Б.О.Х "Шүхэр зүйл" эко клуб | Facebook](#) авна уу. Төсөл хэрэгжүүлэгч багийн талбарт хийгдсэн судалгааны ажлын үед ажиглалтаар эко клубын тухайд COVID-19 цар тахлаас шалтгаалан үйл ажиллагаа нь хумигдсан, гишүүн сурагчдын тоо цөөрсөн байдал ажиглагдаж байна. /Эко клубын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн 2021-2024 оны хооронд хэрэгжүүлж байгаа “Их говийн нүүдэлч малчдыг дэмжин хавтгай тэмээг хамгаалах” төслөөс авч болно/

4.5. Зорилт 5. Малчдын байгалийн нөөцийг тогтвортой ашиглалт, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих

Судалгаанд оролцогчдоос байгаль хамгаалал болон ГИДЦГ-ын Орчны бүсийн менежментийн тогтолцооны талаарх малчдын ойлголт, хандлагыг тодорхойлох нөхцлүүдийг ач холбогдолын түвшингээр үнэлүүлээ.

Эдгээр нөхцлүүдийн хүрээнд маш их ач холбогдолтой гэдэг хариулт гурван бодомжид өндөр хувьтай гарчээ. Тухайлбал, Нүүдлийн өв соёлыг хадгалах, өвлүүлэх (73%), Байгалийн усыг зэрлэг амьтанд нь үлдээх (51%) болон Дэлхийн ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх, хамгаалах (51%) нь маш их ач холбогдолтой гэж үзсэн байна. Мөн бэлчээрийн даацыг тэнцвэржүүлэх, газрын доройтолыг багасгахад нэг малчин өрхийн малын дээд хязгаарыг зааж өгөх нь ямар ч ач холбогдолгүй (20%), ач холбогдол бага (10%), дундаж ач холбогдолтой (12%), ерөнхийдөө ач холбогдолтой (29%), маш их ач холбогдолтой (28%) гэж тус тус үнэлжээ. Байгаль хамгаалал болон орчны бүсийн менежментийн тогтолцооны талаарх малчдын ойлголт, ямар үзэл бодолтойг тодорхойлох зорилго бүхий бодомжуудыг ач холбогдолын түвшингээр Хүснэгт 28-нд дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 28. Бодомж ач холбогдолын түвшингээр, %, N=69

№	Бодомж	Ач холбогдолын түвшин					
		Ямар ч ач холбогдолгүй	Ач холбогдол бага	Дундаж ач холбогдолтой	Ерөнхийдөө ач холбогдолтой	Маш их ач холбогдолтой	Дундаж утга
1	Дэлхийн ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх, хамгаалах	3%	3%	9%	35%	51%	4.28
2	Байгалийн усыг зэрлэг амьтанд нь үлдээх	1%	1%	9%	38%	51%	4.35
3	Нүүдлийн өв соёлыг хадгалах, өвлүүлэх	1.4%	1.4%	1%	23%	73%	4.64
4	Ховордсон амьтдын үржүүлгийн газар байгуулах	7%	7%	25%	32%	29%	3.68
5	Малын тоо толгойг хянах замаар бэлчээр сэргээх	4%	3%	12%	36%	45%	4.14
6	Бэлчээр ашиглалтыг нөхөрлөл, бүлэгт эзэмшүүлэх, хариуцуулах замаар зохицуулах	3%	9%	20%	33%	33%	3.87
7	Нэг малчин өрхийн малын дээд хязгаарыг зааж өгөх	20%	10%	12%	29%	28%	3.34

Дээрх бүлэг бодомжыг хоёр хэсэгт хуваан байгаль хамгалал, бэлчээр хамгаалалын хандлагад индекс тооцов. Өөрөөр хэлбэл тодорхой нэг нөхцөл байдлын шалгуур үзүүлэлт хангагдсан буюу 3 ба түүнээс дээш тохиолдолд тэрхүү үзүүлэлт хангагдсан гэж үзээд, тодорхой нэг нөхцөл байдлын бүх шалгуурт үзүүлэлт хангагдсан тохиолдолд тухайн оролцогчыг байгаль хамгаалал болон орчны бүсийн менежментийн тогтолцооны талаар мэдлэг, ойлголттой байна гэсэн арга зүйг баримтлан, нөхцөл байдал тус бүрийн хувьд индекс оноог гарган Хүснэгт 29-нд дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 29. Байгал хамгалал, бэлчээр ашиглалтын мэдлэг, хандлагын индекс оноо

Нөхцөл байдал	Шалгуур үзүүлэлт	Индекс оноо
---------------	------------------	-------------

Байгаль хамгаалал	Дэлхийн ховордсон ан амьтдыг нөхөн сэргээх, хамгаалах	53.62
	Байгалийн усыг зэрлэг амьтанд нь үлдээх	
	Нүүдлийн өв соёлыг хадгалах, өвлүүлэх	
	Ховордсон амьтдын үржүүлгийн газар байгуулах	
Бэлчээр хамгаалал	Малын тоо толгойг хянах замаар бэлчээр сэргээх	14.49
	Бэлчээр ашиглалтыг нөхөрлөл, бүлэгт эзэмшүүлэх, хариуцуулах замаар зохицуулах	
	Нэг малчин өрхийн малын дээд хязгаарыг зааж өгөх	

Байгаль хамгалал болон бэлчээр хамгаалалын талаарх малчдын мэдлэг, хандлагад индекс тооцож үзэхэд байгаль хамгаалалын талаарх оролцогчдын индекс оноо 53.62 буюу мэдлэг, хандлага төлөвшиж байна. Харин бэлчээрийн хамгаалалд малын тоо, толгойд анхаарах асуудлын хүрээнд оролцогчдын индекс оноо 14.49 буюу мэдлэг, хандлага муу байна. Эндээс үзэхэд судалгаанд оролцогч малчид бэлчээр хамгаалалд малын тоо, толгойг бууруулах арга замыг ач холбогдолгүй хэмээн үзжээ.

Нийт судалгаанд оролцогчдоос байгаль хамгаалал болон орчны бүсийн менежментийн тогтолцооны талаар малчид ямар хандлагатай болсныг тодорхойлох зорилго бүхий бодомжтой санал нийлэх эсэхийг тодрууллаа. Байгаль хамгаалал болон орчны бүсийн менежментийн тогтолцооны талаар малчид ямар хандлагатай болсныг тодорхойлох зорилго бүхий бодомжтой санал нийлэх эсэхийг Хүснэгт 30-нд дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 30. Дараах бодомжуудад санал нийлэх эсэх, %, N=69

№	Бодомж	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Ерөнхийдөө санал нийлнэ	Маш их санал нийлж байна	Дундаж утга
1	Малчид байгаль хамгаалахад оролцоход төвөгтэй, завгүй	3%	3%	9%	35%	2.46
2	Малчин хүний амжиргаа нь байгаль хамгаалах, бэлчээр сэргээхээс илүү чухал болсон үе	1%	1%	9%	38%	2.61
3	Алсуураа устаж үгүй болж буй зэрлэг амьтдыг хүн өсгөж үржүүлэх хамгаалах нь хэцүү	1.4%	1.4%	1%	23%	2.72
4	Малчдын хүүхдүүд хотод суурьшаад цаашид бэлчээр нутаг, МАА-г сонирхохоо больсон.	7%	7%	25%	32%	3.20
5	Эцэг өвгөдөөс уламжилж авсан нутгийн байгаль, ан амьтан, бэлчээрийг хамгаалахад малчид их үүрэгтэй	4%	3%	12%	36%	3.55
6	Малчид нутгийн байгаль, зэрлэг амьтдыг хамгаалахад чадах бүхнээрээ туслах учиртай.	3%	9%	20%	33%	3.46
7	Нэг үеэ бодвол малчдын амжиргаа их сайжирсан одоо малаа цөөлж, бэлчээрээ нэг сэргээх цаг нь болсон	20%	10%	12%	29%	3.23

Бодомжуудын хүрээнд маш их санал нийлнэ гэдэг хариулт гурван бодомжид харьцангуй өндөр хувьтай гарчээ. Тухайлбал, Малчид байгаль хамгаалахад оролцоход төвөгтэй, завгүй (35%), малчин хүний амжиргаа нь байгаль хамгаалах, бэлчээр сэргээхээс илүү чухал болсон үе (38%), эцэг өвгөдөөс уламжилж авсан нутгийн байгаль, ан амьтан, бэлчээрийг хамгаалахад малчид их үүрэгтэй (36%) маш их санал нийлнэ гэж тус тус хариулжээ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

ГИДЦГ-ын Орчны бүсийн 5 багийн 69 өрхийг судалгаанд хамруулсан ба эдгээрийн 52 нь өрхийн тэргүүлэгч, 14 нь эхнэр эсвэл нөхөр, 3 нь хүү эсвэл охин байсан. Мөн эдгээрийн 75.4% буюу 52 нь эрэгтэй, үлдсэн 24.6% буюу 17 нь эмэгтэйчүүд байсан ба хамгийн залуу нь 20 настай, хамгийн хөгшин нь 79 настай буюу дунджаар 41 насны иргэд хамрагдав. Судалгаанд оролцогч өрхүүд дундажаар 4-5 ам бүлтэй, 4-5 хүүхэдтэй, өрхийн тэргүүлэгч эсвэл гол орлого ологч нь нутагтаа дунджаар 38 жил амьдарч байгаа өрхүүд судалгаанд хамрагджээ. Өрхийн гишүүдийн үндэс, угсааны хувьд 100% халх ястан бүхий өрх байна.

Нийт өрхийн гишүүдээс эмзэг бүлэгт хамрагдах гишүүдийн тоо 12 буюу нийт гишүүдийн 3.9% эзэлж байна. Үүний 1 нь өнчин, 2 бэлэвсэрсэн, 9 хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байна.

Өрхийн насанд хүрсэн гишүүдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байсан бол, харин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гишүүн 94.2% буюу өндөр байна. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн БЖИ-ийн үзүүлэлтээс харахад 40.39% нь жингийн илүүдэлтэй, таргалалттай бол, 51.9% эрүүл, 6.2% туранхай буюу хоол тэжээлийн хомсдолтой байна.

Зорилтот багуудын хувьд амьжиргааны түвшнийг илтгэдэг олон хэмжээст ядуурлын индекс 0.114 гарсан. Нийт өрхөд эзлэх ядуу өрхийн 28.2% гарсан ба эдгээр ядуу өрхийн 40.6% нь бүх шалгуур үзүүлэлтийн хувьд гачигдалтай байна. Өрхүүдийн хөрөнгө эзэмшил болон нялхсын эндэгдлийн үзүүлэлтүүд боломжийн түвшинд байсан боловч амьжиргааны түвшний бусад үзүүлэлт дээр маш хангалтгүй хэмжээнд байна. Ядуу өрхийн хувь өндөр гарахад ундны усны найдвартай эх үүсвэр, ариун цэврийн нөхцөл байдал, гэр, байр, орон сууцны шалны материал, хоол унд хийх түлш хамгийн их нөлөөлсөн байна. Өрхүүдийн 90-ээс дээш хувь нь ариун цэврийн нөхцөл байдал болон хоол унд хийх түлшний байдлыг илтгэдэг үзүүлэлтийн хувьд гачигдалтай байсан бол 80-аас дээш хувь нь ундны усны найдвартай эх үүсвэр, гэр, байр, орон сууцны шалны материалын үзүүлэлтийн хувьд гачигдалтай байна.

Орчны бүсийн өрхүүдийн амьжиргааны нөхцөл байдлыг 2020 онтой харьцуулахад 2021 онд өрхийн орлого 8.6% өссөн боловч түүнийг дагаад зарлагын хэмжээ 7.7% өссөн байна. Баянхонгор аймгийн, Баян-Өндөр сумын Идрэн баг, Шинэжинст сумын Уртын гол багуудад өндөр өсөлттэй гарсан бол Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт багт 4.6%-аар буурсан байна. Баянхонгор аймгуудын зорилтот багуудад өрхийн орлого өсөлттэй гарсан боловч өрхүүдийн орлогын хүрэлцээний хувьд хэрэгцээнээсээ илүүчилж хуримтлуулах байдал Говь-Алтай аймгуудын багуудад өндөр байгаа бол өдөр тутмын хэрэгцээгээ хангаж чадахгүй байдал Баянхонгор аймагт өндөр байна.

Орон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр нь уламжлалт мал аж ахуй учраас гол орлого нь сүүн бүтээгдэхүүн, ноос, махны борлуулалт байна. 2020 онтой харьцуулахад 2021 онд өрхийн ноос ноолуурын орлого нэмэгдсэн бол мал зарах, малын махнаас олох орлогын хэмжээ буурсан байна.

Өрхийн хадгаламжийн нөхцөл байдлын хувьд нийт өрхийн ердөө 31.9% хадгаламжтай байна. Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт баг болон Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт багуудын өрхүүдийн талаас илүү хувь нь хадгаламжтай байна.

2020 онтой харьцуулахад 2021 онд зээлтэй өрхийн хувь 8.7%-аар өссөн ба зээлтэй өрхийн хувь зорилтот бүх багт нэмэгдсэн байдалтай байна.

Нөхөрлөлийн дундын хуримтлалын санд хамрагдах байдал тун хангалтгүй, нийт өрхийн ердөө 2.9% нь хуримтлалын санд хамрагдсан байна. Мөн 5 өрх тутмын зөвхөн 1 нь орлого зарлагаа тэмдэглэж, эдийн засгийн тооцоо хийж байна. Өрхийн орлого зарлагаа тэмдэглэж эдийн засгийн тооцоо хийх байдал Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол багт хамгийн өндөр буюу 35.6% байгаа бол Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Өлзийт баг хамгийн бага буюу 13.3% байгаа нь зорилтот багийн өрхүүдийн орлого зарлага хянах байдал сул байгааг харуулж байна.

Орчны бүсийн малчдын үзэж буйгаар заган ой, бэлчээр, зэрлэг ан амьтадын тоо толгой сүүлийн 3 жилийн хугацаанд буурсан хэмээн үзэж байна. Нөхцөл байдал ийнхүү доройтоход хур тундас багасах, уст цэгийн тоо буурах, малын тоо ихсэх, уул уурхай нэмэгдэх зэрэг шалтгаан нөлөөлж байна.

Зэрлэг амьтнаас хамгийн их харагдац сайтай нь Хар сүүлт, чоно байгаа бол, хамгийн харагдац муу нь Цоохор ирвэс, Хулан байна. Сүүлийн жилүүдэд хулгайн ан, заг бэлтгэх, эмийн ургамал түүх, бичил уул уурхай эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орсон эсэхийг тодруулахад мэдэхгүй, хэвэндээ гэсэн хариулт давамгайлж байна.

Бэлчээрийг сэргээж хамгаалахад чиглэлд иргэдийн зүгээс уст цэгийн тоог нэмэгдүүлэх, худаг гаргах, малын тоог бууруулах, чанаржуулах, бэлчээрийг хашаалах, өнжөөх, сэлгэн нүүдэллэх, үүлэнд нөлөөлж бороо оруулах гэсэн саналуудаар хязгаарлагдаж байна.

ГИДЦГ-ын Орчны бүсэд амьдарч байгаа иргэд ГИДЦГ-ын Орчны бүсийн менежментийн талаар мэдлэг, мэдээлэл бага байна. БНХМ нөхөрлөлд гишүүнчлэлтэй эсэхийг тодруулахад 24.6% нөхөрлөлд гишүүнчлэлтэй ба нөхөрлөлийн хувьд байгаль орчин, худалдаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Санал зөвлөмж

- ГИДЦГ-ын Орчны бүсийн малчин өрхүүдийн орлого дан мал аж ахуйгаас хамааралтай байна. Төслийн үйл ажиллагааны хүрээнд өрхийн орлогын олон төрөлт байдлыг дэмжсэнээр байгаль орчныг хамгаалах, малын тоог бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой. Үүний зэрэгцээ малчдын малаас гарч байгаа түүхий эдийг боловсруулах (нийт өрхийн 93% нь сарлагтай) болон мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бусад төрлийн гар урлалын аж ахуйг дэмжих боломж байна.
- Нөхөрлөл болон нөхөрлөлийн дундын сангийн үйл ажиллагааг малчдад танилцуулах, мэдлэг олгох болон өрхийн орлого зарлагаа хөтлөх, хянах сургалт, хурал, цуглаан зохион байгуулах хэрэгцээ байна. ГИДЦГ-ын "А" хэсгийн орчны бүсэд Герман, Монголын хамтарсан "KfW"-н "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нь" хөрөнгө оруулалтын төсөл болон БОАЖЯ, НҮБ-н хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслүүд зорилтот 5 баг болон бусад ойролцоох сумдад хэрэгжиж байна. Эдгээр төслүүдээс өөр төслүүд хэрэгжсэн байх магадлалтай тул судлах шаардлагатай. Хэрэгжсэн болон хэрэгжиж буй төслүүд нь үйл ажилгааныхаа хүрээнд малчдад түшиглэсэн нөхөрлөл болон нөхөрлөлийн дундын санг байгуулсан байна. "Их говийн нүүдэлч малчдыг дэмжин хавтгай тэмээг хамгаалах" төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө эдгээр нөхөрлөл, нөхөрлөлийн дундын сангын үйл ажиллагааг судлах хэрэгцээ байна.
- Орон нутгийн иргэдийн хамгийн ихээр санаа зовниж буй асуудал бол усны хүрэлцээ, хангамжийн асуудал байна. ГИДЦГ-ын Орчны бүсээс малчдын холдуулах арга замын нэг нь уст цэг, худгуудыг өөр шинэ газарт байгуулах замаар Орчны бүс дэх малчдын нягтаршлыг сийрэгжүүлэх боломж байна.
- Заган ойн нөхцөл байдал сүүлийн 3 жилийн хугацаанд муудаж байгааг нутгийн иргэд хүлээн зөвшөөрч байгаа ба гол хэрэглэгч, сүйтгэгч нь нутгийн иргэд өөрсдөө болж, загийг түлшинд хэрэглэж байна. Тиймээс нутгийн иргэдэд чиглэсэн заган ойг хамгаалах сурталчилгаа хийх, мөн загийг түлшнээс өөр төрлийн илүү үнэ цэнэтэй хэрэглээнд оруулах, өөр түлшээр оруулах боломжийг судлах, нэвтрүүлэх хэрэгцээ байна.
- Хулгайн ан, заг бэлтгэх, эмийн ургамал түүх үйл ажиллагаа нь тогтсон саруудад үйлдэгдэж байна. Тиймээс төслөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж буй эргүүл, хамгаалалын тогтолцоо болон камерын хяналтын системийг тухайн саруудад идэвхтэй, оновчтой болгон ажилласнаар үр дүнд хүрэх боломжтой.
- Нутгийн иргэдийн дунд ГИДЦГ-ын Орчны бүсийн менежмент болон үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл бүхий иргэд цөөн байна. Тиймээс орчны бүсийн менежмент болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг нутгийн иргэдэд зөв оновчтой байдлаар хүргэх шаардлага байна. Мөн нутгийн иргэдийн 43.5% нутгийнхаа амьтан, ургамлын талаар дунд зэргийн мэдлэгтэй эсвэл огт мэдэхгүй гэсэн хариултыг өгч байна. Тиймээс иргэдийн амьдарч буй нутгийнхаа амьтан, ургамлын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлага байна.
- Орон нутгийн иргэд байгаль орчин, цаг агаарын мэдээллийг зөвхөн телевизээс авч байна. Тиймээс нутгийн иргэдийг мэдээллийг олон эс үүсвэрээс авах боломжийг нэмэгдүүлэх нь чухал байна.